

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН БОЛОН ТЭДГЭЭРИЙН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

(Харьцуулсан судалгаа)

Д.Халиун, Р.Оргилмаа

АГУУЛГА

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Афганистан (2011-2016)
- Замби (2015-2019)
- Тринидад Ба Тобаго (2013-2018)
- Кирибати (2017-2022)
- Өмнөд Африк (2014-2019)
- Руанда (2011-2015)
- Сьерра Леон (2016-2019)
- Уганда (2014-2018)
- Пакистан (2014-2018)
- Бутан (2014-2018)
- Киргиз (2016-2021)
- Соломоны Арлууд (2017-2021)

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Австрали
- Их Британи
- Молдова
- Шинэ Зеланд

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ


Энэхүү судалгаанд гадаадын улс орнуудын Парламентын стратеги төлөвлөгөө, зорилго, зорилтуудыг харьцуулсан болно. Мэдээллийн хайлт хийж судлахад 13 улс (Афганистан, Бутан, Замби, Зимбабве, Кирибати, Киргиз, Соломоны Арлууд, Сьерра Леон, Тринидад ба Тобаго, Өмнөд Африк, Пакистан, Руанда, Уганда)¹³⁸ Парламентын стратеги төлөвлөгөөгөө олон нийтэд нийтэлсэн байна. Үүнээс гадна гадаадын зарим орны хувьд Парламентын аппарат буюу ажлын албаны стратеги төлөвлөгөө¹³⁹ (Австрали, Бангладеш, Канад, Их Британи, Молдова, Шинэ Зеланд зэрэг), эсхүл муж улсын түвшний хууль тогтоох байгууллагын стратеги төлөвлөгөө (тухайлбал: Австрали, Канадын муж улсууд, Шотланд гм.), эсхүл тодорхой чиглэлээр, тухайлбал: Парламентын МХХТ-ийн Стратеги төлөвлөгөө зэргийн хүрээнд батлан хэрэгжүүлж байна.

Судалгаанд хамрагдсан 13 улсын Парламентын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааны хувьд 3-5 жил байх ба үүний талаас дээш хувь нь 4 жил байх бол 1/3 нь 5 жилээр төлөвлөсөн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Парламентын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа

Парламентын Стратеги төлөвлөгөөний хугацаа		
3 жил	1 улс	Сьерра Леон
4 жил	7 улс	Бутан, Пакистан, Руанда, Соломоны Арлууд, Уганда, Киргиз, Замби
5 жил	5 улс	Афганистан, Кирибати, Өмнөд Африк, Тринидад ба Тобаго, Зимбабве

Судалгаанд хамрагдсан 13 улсаас 7 улсын Стратеги төлөвлөгөөний хугацаа дууссан боловч, шинэчлэн нийтлэгдээгүй байгаа бол 6 улсын Стратеги төлөвлөгөө хүчин төгөлдөр хэрэгжиж байна.



¹³⁸Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудын Парламентын стратеги төлөвлөгөөг гол төлөв олон улсын байгууллагууд (Олон улсын парламентын холбоо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Хамтын нөхөрлөлийн орнуудын холбоо, Parliamentarians for Global Action-PGA, The Association of European Parliamentarians with Africa -AWEPA)-ын төсөл, хөтөлбөрийн хүрээнд боловсруулан, хэрэгжүүлж байна.

¹³⁹Гадаадын зарим улс орнуудын Парламентын аппарат буюу ажлын албаны стратеги төлөвлөгөөг Хавсралт 3-аас дэлгэрүүлж үзнэ үү.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын тоо хэмжээний хувьд судалгаанд хамрагдсан улс орнууд 4-6 үндсэн зорилт дэвшүүлсэн бол 5 улс нийт 6 стратеги зорилт, харин 4 улс 4-5 стратеги зорилт тус тус дэвшүүлсэн байна. Парламентын стратеги төлөвлөгөөнд парламентын чиг үүрэгтэй холбоотой асуудлыг улс орнууд хэрхэн эрэмбэлснийг Хүснэгт 2-оос үзнэ үү.

Парламентуудын стратегийн тэргүүлэх чиглэлийг хэрхэн тодорхойлсныг авч үзвэл парламентын гол чиг үүргүүд болох хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудаас гадна Парламентын Аппарат буюу ажлын албатай холбоотой асуудлыг дийлэнх парламентууд стратеги төлөвлөгөөндөө тусгасан байна. Үүнээс парламентын хяналтын, төлөөллийн чиг үүрэгтэй холбоотой асуудлыг судалгаанд хамрагдсан бүх парламент бие даасан зорилт болгон тусгасан бол хууль тогтоох чиг үүрэгтэй холбоотой асуудлыг 12, Парламентын ажлын албатай холбоотой асуудлыг 11 улс тусгасан байна. Парламентын гадаад харилцаатай холбоотой асуудлыг нийт 4 улс бие даасан зорилт болгон дэвшүүлсэн байгаа бол зарим орнуудад парламентын хөгжлийн түвшин, улс орны нөхцөл байдал зэргээс хамааран Парламентын бие даасан, хараат бус байдал (*Parliamentary autonomy*), сонгуульт албан тушаалтны чадавх (MP's capacity), Парламентын дэд бүтэц, Цахим парламент (*e-Parliament*), Парламентын сургалт, судалгааны нэгж, Үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх механизм (*National development goals*), жендэрийн эрх тэгш байдал (*gender mainstreaming*) зэрэг асуудлыг бие даасан стратеги зорилт болгон дэвшүүлсэн байна. (Хүснэгт 3) Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 2. Парламентын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн зорилтууд, тэдгээрийг эрэмбэлсэн байдал

Улс	Хууль тогтоох үйл ажиллагаа	Хяналтын үйл ажиллагаа	Үйл ажиллагааны ил тод байдал, төлөөллийн чиг үүрэг	Гадаад харилцаа	Парламентын ажлын алба	Бусад	Нийт зорилтын тоо
Афганистан	1	2	4	-	5	3,6	6
Бутан	2	3	4	-	1	-	4
Кирибати	2	3	4	-	5	1	5
Пакистан	1	2	3	-	4	5,6	6
Руанда	1	2	4	5	6	3	6
Сьерра Леон	2	3	4	-	1	-	4
Соломоны арлууд	2	3	4	-	-	1	4
Өмнөд Африк	5	1	3	4	6	2	6
Тринидад ба Тобаго	2	3	4	-	-	1	4
Уганда	-	3	2	5	1	4,6	6
Киргиз	2	3	1	5	4	-	5
Замби	1	2	4	-	+ ¹⁴⁰	3,5	5
Зимбабве	1	2	3	-	4	5	5
Нийт	12	13	13	4	11		

¹⁴⁰Замби Улсын Парламентын стратеги төлөвлөгөө нь Парламентын үйл ажиллагаатай холбоотой болон Парламентын ажлын албатай холбоотой гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна.

Хүснэгт 3. Парламентын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан (бусад) зорилтууд

Бусад	Парламентын хараат бус, бие даасан байдал, гишүүдийн чадавх	Барилга байгууламж, дэд бүтэц	Цахим парламент	Сургалт, судалгаа	ҮХ-р тогтоосон суурь зарчим, Үндэсний хөгжлийн зорилтууд	Төсөв	Жендэр	ЗГ-тай харилцах харилцаа
Афганистан	v	v						
Кирибати	v							
Пакистан			v	v				
Руанда					v			
Соломоны Арлууд	v							
Өмнөд Африк								v
Тринидад ба Тобаго	v							
Уганда		v			v			
Замби	v					v		
Зимбабве							v	

Улс орнуудын Стратеги төлөвлөгөөнд түүнийг боловсруулах болсон үндэслэл, шалтгаан, нөхцөл байдлын судалгаа (Киргиз), хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө/Implementation roadmap (Бутан, Сьерра Леон, Руанда, Киргиз), хүрэх үр дүн/milestones, хүлээгдэж буй үр дүн/expected results (Пакистан, Руанда), шалгуур үзүүлэлт (Өмнөд Африк, Уганда), төсөв (Өмнөд Африк, Киргиз), хяналт шинжилгээ (Руанда) зэргийг тусгасан байна.

Улс	Хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө	Хүрэх үр дүн/ milestones	Шалгуур үзүүлэлт/ Indicators	Төсөв	Хяналт шинжилгээ /Monitoring and evaluation	Бусад
Афганистан	-	-	-	-	President of the House and the Administrative Board	Annual evaluation Final evaluation (2016)
Руанда	Timeframe	Expected results	Performance indicators	Budget	Steering Committee Internal Committee in each Chamber	Annual evaluation Mid-term evaluation (2013) Final evaluation (2015)

Тринидад ба Тобаго	-	-	-	-	Project Implementation, Monitoring and Evaluation Unit	Two-monthly written updates. An annual written report. Mid-term review of the Strategic Plan, conducted by an external, independent consultant as selected and recruited by the Office of Parliament
Уганда	-	Means of verification	Performance indicators +	-	Independent consultants commissioned by Parliamentary Commission.	Annual evaluation Mid-term evaluation (2016) Final evaluation

ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН ЗОРИЛТУУДЫГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН ЗОРИЛТУУДАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

1. Монгол	Стратеги зорилт 1. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх	Стратеги зорилт 2. Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэх.	Стратеги зорилт 3. Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан арга хийл ажиллагааныхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах.	Стратеги зорилт 4. Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.	Стратеги зорилт 5. Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах.	Бусад
2. Кирибати ¹⁴¹	Зорилт 2 – Парламентаас баталсан хууль, тогтоомж нь оролцоог ханган боловсруулагдаж, эрхэд суурилсан, оролцоон дээр тулгуурласан, тулгуурласан, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн байна	Зорилт 3 – Парламент нь Засгийн газарт үр дүнтэй хяналт тавих замаар эрхэд суурилсан, оролцоон дээр тулгуурласан, тогтвортой хөгжлийг хангахад төрийн сангийн эх үүсвэрийг хамгийн дээд хэмжээнд байлгана	Зорилт 4 – Парламент иргэдийн парламентын ардчилалд итгэх итгэлийг бэхжүүлэхэд улс даяар иргэд, олон нийттэй харилцах харилцааг идэвхтэй хөгжүүлж, илүү нээлттэй ил тод, оролцоог хангасан байгууллага байна		Зорилт 5 – Спикер, Парламентын гишүүд болон бусад гол үйлчлүүлэгч бүлгүүдэд үр нөлөөтэй, мэргэжлийн, өндөр чанартай дэмжлэг үзүүлэх Парламентын тамгын газрын чадавхыг дээшлүүлэх	Зорилт 1 – Парламентын Спикер болон гишүүд Үндсэн хуулиар баталгаажсан болон ардчилсан үнэт зүйлсийг сурталчилж, хариуцлагатай удирдагч нар хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байх
3. Киргиз Улс ¹⁴²	3.2. Хууль тогтоох үйл ажиллагаа	3.3. Хяналтын үйл ажиллагаа	3.1. Төлөөллийн үйл ажиллагаа	3.5. Олон улсын үйл ажиллагаа	3.4. Дүн шинжилгээний үйл ажиллагаа	
4. Соломоны Арлууд ¹⁴³	2. Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгох	3. Парламентын Засгийн газарт үр дүнтэй хяналт тавих чадавхыг сайжруулах	4. Парламентын боловсрол, олон нийттэй харилцах болон гишүүдийн		1. Парламентын улсад үйлчлэх чадавхыг хөгжүүлэх; Парламентын	

¹⁴¹ Kiribati Parliament Corporate Strategic Plan (2017-2022) https://agora-parl.org/sites/default/files/kiiribati_parliament_corporate_strategic_plan_final_may_2010.pdf

¹⁴² СТРАТЕГИЯ развития Жогорку Кеңеша Кыргызской Республики до 2021 года <http://cbd.miniust.gov.kg/act/view/ru-ru/82056>

¹⁴³ National Parliament of Solomon Islands Strategic Plan 2017-2021 <http://www.parliament.gov.sb/files/Parliament%20Strategy/mpi17To21.pdf>

	замаар хууль тогтоомжийн чанарыг сайжруулах	төлөөллийн чиг үүргийг сайжруулах	ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх.	
5.	Сьерра Леон ¹⁴⁴	Зорилт 2: Хууль тогтоох чадавхыг бэхжүүлэх	Зорилт 4: Парламентыг нээлттэй болгох	Зорилт 1: Институцийн чадавхыг бэхжүүлэх
6.	Замби ¹⁴⁵	Стратеги зорилт 1: Үндэсний Ассамблейн хууль тогтоох чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх.	Стратегийн зорилт 2: Хууль тогтоох байгууллагын гүйцэтгэх эрх мэдэлд үр дүнтэй хяналт тавих чадавхыг бэхжүүлэх. Стратегийн зорилт 3: Үндэсний Ассамблейн Үндэсний төсвийн мөчлөгт үр дүнтэй оролцох чадавхыг бэхжүүлэх.	Парламентын Захиргааны (Administration) стратегийн зорилтууд Стратеги зорилт 1: Үндэсний Ассамблейд чиг үүргээ үр дүнтэй биелүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг бэхжүүлэх. Стратегийн зорилт 2: Захиргааны үйлчилгээг сайжруулах. Стратегийн зорилт 3: Парламентын гишүүд, ажилтнууд албан үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэхэд чиглүүлэн дэд бүтцийг хөгжүүлэх.
7.	Өмнөд Африк ¹⁴⁶	1.7.5 Үндсэн хуулиар хүлээсэн хууль тогтоох үүргээ хэрэгжүүлэхэд нь Парламентын чадавхыг нэмэгдүүлэх	1.7.1 2014-2019 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэхэд	1.7.4 Парламентын олон улсын хамтын ажиллагааг сайжруулах 1.7.6. Парламентын гишүүдэд Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь үр өгөөжтэй, чадварлаг
			1.7.3 Олон нийтийн оролцооны загварыг хэрэгжүүлэх замаар ардчиллыг хөгжүүлэхэд 2019 он гэхэд Парламентын	1.7.2. Нэгдмэл ашиг сонирхлын асуудлаар төр, засгийн бусад салбартай хамтран ажиллаж, засгийн

¹⁴⁴ Strategic Plan of the Parliament of Sierra Leone 2016-2019. With the support of United Nations Development Programme (UNDP) https://agora-parl.org/sites/default/files/parliament_strategic_plan_final-sierra_leone.pdf

¹⁴⁵ Парламент болон Тамгын газрын Стратеги төлөвлөгөө, <http://www.parliament.gov.zm/sites/default/files/documents/pages/Final%20National%20Assembly%20of%20Zambia%20Strategic%20Plan%281%29.pdf>

¹⁴⁶ STRATEGIC PLAN FOR THE 5th DEMOCRATIC PARLIAMENT 2014-2019 <https://www.parliament.gov.za/storage/app/media/StratPlan/5/strat%20plan%2013may2015.pdf>,

8.	Пакистан ¹⁴⁷	Зорилт 1. Хууль тогтоомжтой холбоотой бүх асуудлыг Пакистаны ард түмэнд үр нөлөөтэй, үр ашигтай байхаар бэхжүүлэх;	гүйцэтгэх засаглалын ажилд тавих парламентын хяналт, хариуцлагыг дээшлүүлэх Зорилт 2. Хяналтыг бүх цаг үеийн турш, бүхий л түвшинд, ялангуяа Парламентын Хороодын түвшинд, ил тод байдал давамгайлж, цаг хугацаа, нөөцийн зохистой ашиглалтад хариуцлага хүлээлгэх боломжтой байхаар баталгаажуулах;	үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх Зорилт 3. Ассамблейн төлөөллийн чиг үүргийг сайжруулах замаар Ассамблейн шударга байдлыг сахиж, илүү мэдээлэлтэй, сонгогч, төлөөлж буй тойргуудынхаа хүндлэл хүлээсэн болгох;	үйлчилгээ үзүүлэх Зорилт 4. Танхимын бүхий л чиг үүрэг, үйл ажиллагааг үр ашигтай болгох; Зорилт 5. Мэдээлэл Харилцаа Холбоо, Технологи (МХТ)-д бүтцийн шинэчлэл хийх замаар уламжлалт горимоос автоматжуулсан E-парламентад (цахим парламентад) шилжих. Зорилт 6. PIPS (Пакистаны Парламентын үйлчилгээний хүрээлэн)-г Үндэсний парламентын гишүүд болон албан хаагчид, орон нутгийн 4 парламентад зориулсан сургалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх хүрээлэн болгон бэхжүүлэх.	газар хоорондын харилцааг бэхжүүлэх
9.	Уганда ¹⁴⁸	Стратеги зорилт 3 Байгууллагын хяналт-	Стратеги зорилт 2 Парламентын үйл	Стратеги зорилт 5 Угандайн гадаад	Стратеги зорилт 1 Парламентын бүрэн	Стратеги зорилт 4 Парламентын

¹⁴⁷ Strategic Plan 2014-2018 of the National Assembly of Pakistan http://www.na.gov.pk/uploads/1439219002_845.pdf

¹⁴⁸ Uganda - Five-year strategic plan for the Parliament (2014-2018) https://agora-parl.org/sites/default/files/uganda_-_five-year_strategic_plan_for_the_parliament_2014-2018.pdf

			шинжилгээ, үнэлгээний үр дүнтэй тогтолцоог бий болгох замаар Парламентын хариуцлагын гүйцэтгэх эрх мэдэлд тогтолцоог бэхжүүлэх	ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх - хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих	бодлогын хүрээнд Парламентын гадаад харилцаа, олон улсын оролцоог сайжруулах	эрхээ хэрэгжүүлэх чадавхыг нь бэхжүүлэх	шударга, тогтвортой хөгжлийн үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд оролцох Стратеги зорилт 6 Үр ашиг, бүтээмжийг сайжруулахад Парламент (танхим, хорооны өрөө, машины зогсоол, оффис гэх мэт)-ын барилга байгууламжийг өргөтгөх
10.	Буган ¹⁴⁹	Стратеги зорилт 2 Үндэсний Ассамблейн хууль тогтоох чадавх, үйл ажиллагааг сайжруулах;	Стратеги зорилт 3 Үндэсний Ассамблейн хяналт тавих чадавхыг нэмэгдүүлэх;	Стратеги зорилт 4 Үндэсний Ассамблейн төлөөллийн болон олон нийттэй харилцах чадавхыг нэмэгдүүлэх.		Стратеги зорилт 1 Үндэсний Ассамблейн Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх;	
11.	Тринидад ба Тобаго ¹⁵⁰	Стратеги зорилт 2: Хууль тогтоох үйл ажиллагаа	Стратеги зорилт 3: Гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналт	Стратеги зорилт 4: Олон нийттэй харилцах ба төлөөллийн чиг үүрэг		Стратеги зорилт 1: Институцийн чадавх	
12.	Афганиста н ¹⁵¹	Стратеги зорилт 1 – Ардын танхим (доод танхим)-ын хууль тогтоох үйл ажиллагааг сайжруулах	Стратеги зорилт 2 - Ардын танхим (доод танхим)-ын гүйцэтгэх эрх мэдэлд үр дүнтэй хяналт тавих чадавхыг сайжруулах	Стратеги зорилт 4 – Ардын танхим (доод танхим)-ын олон нийттэй харилцах харилцааг сайжруулах		Стратеги зорилт 5 – Парламентын үр ашгийг хамгийн их байлгахад бүтэц, зохион байгуулалтын чадавхыг сайжруулах	Стратеги зорилт 3 – Парламентын гишүүдийн манлайлал, төлөөллийг үүргийн бэхжүүлэх

¹⁴⁹ Strategic development Plan 2014-2018. With the support of United Nations Development Programme (UNDP)

¹⁵⁰ <http://www.nab.gov.bf/assets/uploads/docs/download/2015/strategicplan.pdf>

¹⁵¹ Wolesi Jirga Strategic Plan 2011-2016 (Tecen) https://agora-parl.org/sites/default/files/afghanistan_-_wolesi_jirga_strategic_plan_2011-2016.pdf

							Стратеги зорилт 6 – Парламентын (барилта байгууламж) дэд бүтцийг стандартын өндөр түвшинд хүргэх
13. Руанда ¹⁵²	4.1. Стратеги зорилт 1: Парламентын хуулийн төсөл боловсруулах, дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх Зорилт Парламентын хуулийн төсөл боловсруулах, дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх	4.2. Стратеги зорилт 2: Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн механизмыг бэхжүүлэх	4.4. Стратеги зорилт 4: Парламентын олон нийттэй харилцах харилцааг сайжруулах	4.5. Стратеги зорилт 5: Парламентын дипломат ажиллагааг бэхжүүлэх	4.6. Стратеги зорилт 6: Парламентын үйлчилгээний албыг сайжруулах	4.3. Стратеги зорилт 3: Бүгд Найрамдах Руанда Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан суурь зарчмуудыг хэрэглэх механизмыг бэхжүүлэх	

¹⁵² Rwanda - Strategic Plan of the Parliament (2011-2015) <https://agora-parl.org/resources/library/rwanda-strategic-plan-parliament-2011-2015>

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН СТРАТЕГИ ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1.1 АФГАНИСТАН (2011-2016)

Стратеги зорилт 1 - Ардын танхим (доод танхим)-ын хууль тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгох.

- 1.1. Бүх гишүүдэд хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой гарын авлагаар хангаж, сургалт зохион явуулах;
- 1.2. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар гишүүдэд сургалт явуулах;
- 1.3. Хуулийн төсөл санаачлахтай холбоотойгоор гишүүдэд сургалт явуулах;
- 1.4. Ажилтнуудын хуулийн төсөл боловсруулах чадавхыг бэхжүүлэх;
- 1.5. Хууль тогтоох үйл ажиллагаанд Хороодын чадавхыг сайжруулах;
- 1.6. Нээлттэй, ил тод хууль тогтоох үйл ажиллагааг бий болгох;
- 1.7. Хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Гүйцэтгэх эрх мэдэлтэй үр дүнтэй харилцаа холбооны үйл ажиллагаа тогтоох;
- 1.8. Төсвийн хяналт, дүн шинжилгээний чадавхыг бэхжүүлэх;
- 1.9. Хуулийн төслийн явцыг хянах тогтолцоо нэвтрүүлэх;
- 1.10. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх.

Стратеги зорилт 2 - Ардын танхим (доод танхим)-ын гүйцэтгэх эрх мэдэлд үр дүнтэй хяналт тавих чадавхыг сайжруулах

- 2.1. Гишүүдэд хяналт тавихтай холбоотой гарын авлагаар хангаж, сургалт зохион явуулах;
- 2.2. Хороодоор дамжуулан тавих хяналтыг нэмэгдүүлэх;
- 2.3. Хяналтын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог хангах;
- 2.4. Хяналт тавихтай холбоотойгоор Гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцах харилцаа холбоо болон хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;
- 2.5. Гишүүдэд илүү үр дүнтэй судалгаагаар хангах (Судалгааны нэгжийн чадавхыг бэхжүүлэх);
- 2.6. Төрийн хариуцлагын хороо байгуулах (Public Accounts Committee).

Стратеги зорилт 3 - Парламентын гишүүдийн манлайлал, төлөөлөх үүргийг бэхжүүлэх

- 3.1. Гишүүдэд төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарын авлага боловсруулж, сургалт зохион явуулах;
- 3.2. Парламентч эмэгтэйчүүдийн бүлгийн чадавхыг бэхжүүлэх;
- 3.3. Танхимд лобби бүлгүүд байгуулахыг дэмжих (Encourage the establishment of subject interest groups in the House);
- 3.4. Парламент дахь намын бүлгүүдийн хөгжлийн цар хүрээг судлах (Examine the scope for the development of political groups in the Wolesi Jirga).

Стратеги зорилт 4 - Ардын танхим (доод танхим)-ын олон нийттэй харилцах харилцааг сайжруулах

- 4.1. Олон нийттэй харилцах стратеги боловсруулах;
- 4.2. Парламентын радио, телевиз байгуулах;
- 4.3. Парламентын мэдээллийн хуудас, материал хэвлэн нийтлэх;
- 4.4. Сургуулийн хөтөлбөрийг сайжруулах (парламентын боловсрол);
- 4.5. Парламентын цахим хуудсыг шинэчлэн сайжруулах;
- 4.6. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй харилцах харилцааг сайжруулах;
- 4.7. ИНБ-тай харилцах харилцааг сайжруулах;
- 4.8. Залуучуудын парламентыг бэхжүүлэх.

Стратеги зорилт 5 - Парламентын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд институцийн чадавхыг сайжруулах.

- 5.1. Афганистаны Парламентын институцийн чадавхыг бэхжүүлэх;
- 5.2. Ажилтнуудын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- 5.3. Парламент, хороодын үр дүнтэй харилцааны механизмыг бий болгох;
- 5.4. Шинээр сонгогдсон гишүүдийг чадавхжуулах;
- 5.5. Цахим Парламентыг хөгжүүлэх;
- 5.6. Парламентын гишүүдийн Ёс зүйн дүрмийг боловсруулах;
- 5.7. Парламентад жендэрийн эрх тэгш байдлыг хангах;
- 5.8. Парламентыг үр дүнтэй удирдлагаар хангах;
- 5.9. Парламентын Аппаратын (төсөв, хүний нөөцийн бодлогын хувьд) бие даасан болгоход чиглүүлэх;
- 5.10. Олон улсын харилцааг бэхжүүлэх.

Стратеги зорилт 6 - Парламентын (барилга байгууламж) дэд бүтцийг өндөр стандарт, шаардлагад нийцүүлэх.

- 6.1. Парламентын шинэ барилга нь стандартад нийцсэн байх;
- 6.2. Парламентын хэлэлцүүлгийг телевизээр нэвтрүүлэх;
- 6.3. Хэвлэх цехийн үйл ажиллагааг жигдрүүлэх;
- 6.4. Парламентыг аюулгүй, үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- 6.5. Парламентыг орон нутаг дахь төв, явуулын байр байгуулах боломжийг судлах.

1.2.ЗАМБИ (2015-2019)

Стратеги зорилт 1: Үндэсний Ассамблейн хууль тогтоох чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх.

Энэ зорилтын хүрээнд Замби Улсын Үндэсний Ассамблейн хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (а) Парламентын гишүүдийн хууль тогтоомж, Засгийн газрын бодлогын баримт бичгийг шинжлэх/хянах, хувийн хуулийн төсөл санаачлах (Private Member's Bills), Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл (Government Bills)-д нэмэлт, өөрчлөлт оруулах чадавхыг бэхжүүлэх;
- (б) Парламентын хороодын хуулийн төсөл шинжлэх чадавхыг бэхжүүлэх;
- (в) Хууль тогтоомжийг батлах үйл ажиллагаатай холбоотойгоор Танхимын дэг, процедурт нэмэлт, өөрчлөлт оруулах.

Стратегийн зорилт 2: Хууль тогтоох байгууллагын Гүйцэтгэх эрх мэдэлд үр дүнтэй хяналт тавих чадавхыг бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (а) Парламентын хороодын үр дүнтэй хяналт тавих чадавхыг бэхжүүлэх;
- (б) Алсын хараа 2030, Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих Парламентын чадавхыг бэхжүүлэх;
- (в) Парламентын хороодын олон нийтийн хэлэлцүүлэг зохион явуулах механизм, процедурыг боловсруулах;
- (г) Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) болон Парламентын хороодын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

Стратегийн зорилт 3: Үндэсний Ассамблейн Үндэсний төсвийн мөчлөгт үр дүнтэй оролцох чадавхыг бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (а) Төсвийн мөчлөг дэх (National Budget Cycle) Парламентын оролцооны үр нөлөөг дээшлүүлэх хууль эрх зүйн актыг батлах, эсхүл шинэчлэх;
- (б) Парламентын гишүүдийн төсвийн мөчлөгт үр дүнтэй оролцох чадавхыг бэхжүүлэх;
- (в) Парламентын төсвийн албыг байгуулах.

Стратегийн зорилт 4: Үндэсний Ассамблейн төлөөллийг чиг үүргийг бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (а) Парламентын гишүүн – тойрогтойгоо харилцах харилцаа холбоог сайжруулах;
- (б) Парламентын гишүүдийн тойрог дахь оффис (Constituency Office)-ыг Хороодын нээлттэй сонгол зохион явуулах, олон нийтэд хүрч ажиллах зэрэг байдлаар ашиглалтыг оновчлох;
- (в) Үндэсний, бүс нутгийн болон олон улсын гол оролцогч талуудтай шинээр холбоо тогтоох, одоогийн байгаа харилцаа холбоог бэхжүүлэх;
- (д) Олон улсын хурал, форум зэргээс гаргаж буй зөвлөмж, тогтоол шийдвэртэй холбоотой арга хэмжээг хянах механизмыг бий болгох.

Стратегийн зорилт 5: Үндэсний Ассамблейн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (a) Танхимын үйл ажиллагааны хороо (House Business Committee) байгуулах;
- (b) Дэгийг шинэчлэх;
- (c) Парламентын Үйлчилгээний Комисс (Parliamentary Service Commission) байгуулах.

Парламентын Захиргааны (Administration) стратегийн зорилтууд

Стратеги зорилт 1: Үндэсний Ассамблейд чиг үүргээ үр дүнтэй биелүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (a) Парламентын гишүүдийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх;
- (b) Хууль тогтоох байгууллагын чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхэд ажилтнуудын чадавхыг сайжруулах;
- (b) Алсын хараа 2030 болон хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавихад дэмжлэг үзүүлэхэд ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх;
- (г) Парламентын хороодын олон нийттэй харилцах харилцаа болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Стратегийн зорилт 2: Захиргааны үйлчилгээг сайжруулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (a) Хяналт-шинжилгээ, үнэлгээний иж бүрэн хүрээ (comprehensive monitoring and evaluation framework)-г бий болгох;
- (б) Бүх хэлтсийн хувьд баримтжуулсан үйл ажиллагааны системийг (documented operational systems) хөгжүүлэх;
- (в) Хүний эрх, ХДХВ/ДОХ, жендэрийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээл зэрэг асуудлуудыг бодлого, үйл ажиллагаанд тусгах (mainstreaming of cross-cutting issues)¹⁵³;
- (d) Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хянах;
- (e) Парламентын олон нийтийн телевизийн үйлчилгээг сайжруулах;
- (f) Үндэсний Ассамблейн Захиргааны бүтцийг шинэчлэн зохион байгуулах;
- (g) Үндэсний Ассамблейн нөөцийн дайчилгааны стратеги (resource mobilisation strategy)-г боловсруулах.

¹⁵³mainstreaming of cross-cutting issues

<https://www.oecd.org/dac/peer-reviews/Final%20publication%20version%20of%20the%207%20Lessons%20mainstreaming%20cross%20cutting%20issues.pdf>

Стратегийн зорилт 3: Парламентын гишүүд, ажилтнууд албан үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэхэд чиглүүлэн дэд бүтцийг хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- (а) Одоо байгаа дэд бүтцийг сайжруулахын зэрэгцээ Тойргийн төвүүд¹⁵⁴, Замби Улсын Үндэсний Ассамблей дахь гишүүдийн албан өрөө, Парламентын хэлэлцүүлгийн шинэ танхим зэрэг нэмэлт барилга байгууламж шинээр барьж байгуулах, Парламентын зочид буудлыг өргөтгөх;
- (б) МХХТ-ийн Мастер Төлөвлөгөөний хэрэгжилтийг өргөжүүлэх замаар МХХТ-ийн ашиглалтыг сайжруулах;
- (в) Аюулгүй байдлын систем, дэд бүтцийг сайжруулах.

1.3.ТРИНИДАД БА ТОБАГО (2013-2018)

Стратеги зорилт 1: Институцийн чадавх

- 1.1. Парламентын хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх (Building parliamentary autonomy);
- 1.2. Парламентын гишүүдийн үүрэг роль, байр суурийг бэхжүүлэх;
- 1.3. Парламентын хуваарь (үйл ажиллагааны календарьчилсан төлөвлөгөө)-ийг зохион байгуулах; (Organizing the parliament's schedule)¹⁵⁵
- 1.4. Хорооны тогтолцоог бэхжүүлэх;
- 1.5. Парламентын гишүүдийн чадавх, мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх;
- 1.6. Дэгийг шинэчлэх;
- 1.7. Парламентын Аппаратын дотоод удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх;
- 1.8. “Цаасгүй парламент”-руу шилжих, МХХТ-ийн хэрэглээг гүнзгийрүүлэх;
- 1.9. Олон улсын харилцаа холбоог хөгжүүлэх, тогтвортой байлгах;

Стратеги зорилт 2: Хууль тогтоох үйл ажиллагаа

- 2.1. Хууль тогтоох үйл ажиллагааны платформ (хууль бүтээхэд програм хангамж ашиглах (Document Management System)) боловсруулах;
- 2.2. Хууль тогтоох үйл ажиллагааны цаглабарыг тодорхой болгох; (Clarifying the timetable for the legislative process)¹⁵⁶
- 2.3. Хороод дахь хуулийн төслийн шинжилгээ/хяналт;
- 2.4. Хуулийн төслийн үзүүлэх үр нөлөөг судлах;
- 2.5. Хууль тогтоох үйл ажиллагаан дахь бүх гишүүдийн чадавхыг дээшлүүлэх.

¹⁵⁴<https://agora-parl.org/resources/aoe/parliamentaryinstitution/constituency-offices>

¹⁵⁵1.3. Organizing the parliament's schedule

In order to improve its effectiveness and efficiency, and as foreseen in the CPA Benchmarks (2.4.6), the Parliament of Trinidad & Tobago recognises the need to develop an annual parliamentary calendar which aims to confirm at the beginning of each year the dates of regular plenary sessions, timetables for committee meetings, time for interaction with constituents and other major parliamentary activities and conferences throughout the year. The parliamentary Calendar will also foresee in time for parliamentary outreach activities and sufficient time to review the reports of the Auditor General, Public Accounts Committees, reports from other committees and other relevant issues.

¹⁵⁶Kiribati Parliament Corporate Strategic Plan (2017-2020)

Стратеги зорилт 3: Гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналт

- 3.1. Нэгдсэн хуралдааны хүрээнд хяналтыг хэрэгжүүлэх;
- 3.2. Хороодын хүрээнд хяналтыг хэрэгжүүлэх;
- 3.3. Хоёр шинэ хороодоор дамжуулан хяналтыг гүнзгийрүүлэх;
- 3.4. Төсөв, зардалд үр дүнтэй хяналт тавих;
- 3.5. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хянах, шинжилгээ хийх;
- 3.6. Номын сан, судалгаа, шинжилгээний үйлчилгээг сайжруулах замаар хяналтын чадавхыг нэмэгдүүлэх;
- 3.7. Парламент ба Омбудсмэн хоорондын харилцааг бэхжүүлэх;
- 3.8. Бие даасан, хараат бус хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах.

Стратеги зорилт 4: Олон нийттэй харилцах ба төлөөллийн чиг үүрэг

- 4.1. Холбооны харилцааны албаны үйл ажиллагааг шинэчлэх;
- 4.2. Парламентын олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлэх.

1.4.КИРИБАТИ (2017-2022)

Зорилт 1 - Парламентын Спикер болон гишүүд Үндсэн хуулиар баталгаажсан болон ардчилсан үнэт зүйлсийг сурталчилж, хариуцлагатай удирдагч нар хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн байх

- 1.1. Парламентын Спикер, гишүүд болон Нарийн бичгийн дарга манлайллын үүргийг үр дүнтэй биелүүлж, хариуцлагатай, ил тод манлайллыг сурталчилна;
- 1.2. Парламентын гишүүдийн Үндсэн хууль, процедурын болон чухал асуудлаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх;
- 1.3. Оролцоог илүүгээр хангасан Парламентыг бий болгож, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх .

Зорилт 2 - Парламентаас баталсан хууль, тогтоомж нь оролцоог ханган боловсруулагдаж, эрхэд суурилсан, оролцоон дээр тулгуурласан, тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн байна

- 2.1. Хуулийн төслийн шинжилгээ/хяналтын хороог (Bills Scrutiny committee) шинээр байгуулж, оролцоот, хөгжилд чиглэсэн хууль бүтээх үйл ажиллагааг бэхжүүлэх.

Зорилт 3 - Эрхэд суурилсан, оролцоон дээр тулгуурласан, тогтвортой хөгжлийг хангахад төрийн сангийн эх үүсвэрийн үр дүнтэй ашиглалтад Парламент нь Засгийн газарт хяналт тавина

- 3.1. Хороодод тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөлт, явц, тайлагналыг үр дүнтэй, хариуцлагатай болгоход дэмжлэг үзүүлэх;
- 3.2. Кирибатигийн хөгжлийн төлөвлөгөө, Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн хяналтыг сайжруулах;

Зорилт 4 - Парламент нь иргэдийн парламентын ардчилалд итгэх итгэлийг бэхжүүлэхэд улс даяар иргэд, олон нийттэй харилцах харилцааг идэвхтэй хөгжүүлж, илүү нээлттэй, ил тод, оролцоог хангасан байгууллага байна

- 4.1. Парламентын хууль тогтоох, хяналтын үйл ажиллагааны ил тод байдал, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн механизм боловсруулах;
- 4.2. Парламентын ардчиллын талаарх ойлголтыг хөгжүүлэх зорилгоор залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг татан оролцуулахад чиглэсэн олон нийтийн боловсрол, олон нийттэй харилцах хөтөлбөр боловсруулах.

Зорилт 5 - Спикер, Парламентын гишүүд болон бусад гол үйлчлүүлэгч бүлгүүдэд үр нөлөөтэй, мэргэжлийн, өндөр чанартай дэмжлэг үзүүлэх Парламентын Тамгын газрын чадавхыг дээшлүүлэх

- 5.1. Санхүүгийн болон хүний нөөцийн менежментийн үр ашгийг нэмэгдүүлэхэд Парламентын Тамгын газрын эрх, чадавхыг бэхжүүлэх;
- 5.2. Ажиллагсдыг хөгжүүлэх, хадгалахыг дэмжих;
- 5.3. УИХ-д танилцуулах судалгаа, мэдээллийн үйлчилгээг бэхжүүлэх;
- 5.2. Ажилтнуудад тогтмол сургалт (ажлын байран дахь сургалт) зохион явуулах, тогтвортой ажиллуулах;
- 5.3. Парламентын гишүүдэд зориулсан судалгаа, мэдээллийн үйлчилгээг бэхжүүлэх.

1.5.ӨМНӨД АФРИК (2014-2019)

1.7.1 2014-2019 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх засаглалын ажилд тавих парламентын хяналт, хариуцлагыг дээшлүүлэх

- Хяналтын үйл ажиллагааг төсвийн процесс руу чиглүүлж, хяналтын ажлын дарааллыг оновчлох;
- Парламентын хөтөлбөрт хороодод хангалттай хугацаа олгох;
- Энэ чиглэлээр хороод, гишүүдийн чадавхыг бэхжүүлэх;
- Парламентын төсвийн албаны чиг үүргийг өргөжүүлэх;
- Мэдээллийн (судалгаа) үйлчилгээний хурдан шуурхай байдал болон чанарыг сайжруулах;
- Хороодын хуралдаанд хангалттай өрөө байр, тохиромжтой орчныг бүрдүүлэх.

1.7.2. Нэгдмэл ашиг сонирхлын асуудлаар төр, засгийн бусад салбартай хамтран ажиллаж, засгийн газар хоорондын харилцааг бэхжүүлэх

- Засгийн газрын хамтын ажиллагааны механизмыг бий болгох, засгийн газрын хамтын ажиллагааны зарчмуудыг Парламентын чиг үүрэгт тусгах;
- Гүйцэтгэх засаглалын түвшинд удирдлагын илүү үр дүнтэй загваруудыг бий болгож, тэдгээрийг хууль тогтоох ажиллагаанд нэвтрүүлэх замаар хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;
- Төсөвгүй (санхүүжилтийн эх үүсвэргүй) хууль тогтоомжтой холбоотой асуудлаар орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах;
- Танхим, хорооны хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах (ensuring greater legislative sector).

1.7.3 Олон нийтийн оролцооны загварыг хэрэгжүүлэх замаар ардчиллыг хөгжүүлэхэд 2019 он гэхэд Парламентын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

- Олон нийтийн оролцооны загвар (Public Participation Model)-ыг хэрэгжүүлэх;
- Гишүүдийн тойрог дахь үйл ажиллагааг сайжруулах;
- Олон нийтийн боловсрол, оролцооны хөтөлбөрийг сайжруулах;
- Эргэх холбоо, оролцооны механизмыг бий болгох;
- Олон нийтэд хүргэх мэдээллийг сайжруулан, тогтмолжуулах;
- Орон нутгийн иргэдтэй илүү үр дүнтэй хамтран ажиллах;
- Үндэсний хэмжээний ач холбогдол бүхий асуудлаар олон нийтийн оролцоог хангасан арга хэмжээг тогтмолжуулах;
- Иргэдийн дээрх үйл ажиллагаанд оролцуулах боломжийг нэмэгдүүлэх.

1.7.4 Парламентын олон улсын хамтын ажиллагааг сайжруулах

- Олон улсын тавцанд Өмнөд Африкийн ашиг сонирхлыг төлөөлөх чадавхыг нэмэгдүүлэх;
- Ардчилсан бус засаглалын бүтэц, үйл ажиллагааг өөрчлөх, өөрчлөх ажилд дэмжлэг үзүүлэх;
- Харилцан ашиг сонирхол, эв санааны нэгдэл дээр тулгуурласан стратегийн түншлэлийг бий болгох;
- Африкийн асуудлыг хөхиүлэн дэмжих, ялангуяа бүс нутгийн болон эх газрын интеграцийн үүргийн ач холбогдлыг онцлон анхаарч, Африкийн өмнөд хэсгийн хөгжүүлэх нийгэмлэгийн парламент (SADC Parliament) байгуулах замаар илэрхийлж, Пан-Африкийн парламентын хууль тогтоох эрх хэмжээнийхээ хүрээнд өөрчлөлт оруулах;
- Олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, соёрхон батлах механизмыг бэхжүүлэх, Өмнөд Африкийн гэрээгээр хүлээсэн үүрэгт хяналт тавих механизмыг бий болгох.

1.7.5 Үндсэн хуулиар хүлээсэн хууль тогтоох үүргээ хэрэгжүүлэхэд нь Парламентын чадавхыг нэмэгдүүлэх

- 1994 оноос хойш батлагдан гарсан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх;
- Хэрэгжилтийн явц удаашралтай буюу үр дүнгүй байгаа хууль тогтоомжийг тодорхойлох;
- Үндэсний Хөгжлийн Төлөвлөгөө (ҮХТ)-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд бодлого, хууль тогтоомжийн хийдэл, зангилаа асуудлыг (bottlenecks) тодорхойлох;
- ҮХТ-ийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хууль тогтоомжийг тодорхойлж, үйл ажиллагааг идэвхжүүлэх;

- Хууль тогтоомжийн хэмжээнд тулгуурлан парламентын хөтөлбөрийг¹⁵⁷ шинэчлэх (review the parliamentary programme based on volume of legislation), хууль тогтоомжийн төсөл санаачлан боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах Парламентын чадавхыг бэхжүүлэх.

1.7.6. Парламентын гишүүдэд Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь үр өгөөжтэй, чадварлаг үйлчилгээ үзүүлэх

- Гишүүдийг үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх, гишүүдийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг нэвтрүүлж;
- Гишүүдэд шаардагдах мэдээллийн чанар, үнэ цэнийг дээшлүүлэн хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэхэд процедурын, хуулийн, агуулгын зөвлөгөө, судалгаа болон бусад ижил төстэй мэдээллийн үйлчилгээ үзүүлэх албадыг бий болгох;
- Байр, барилга байгууламж, МХХТ, нэхэмжлэл (claims), катеринг үйлчилгээ (хоол), ахуйн үйлчилгээтэй холбоотой үйлчилгээний хязгаарлагдмал нөөцийн ашиглалтыг оновчилж, засвар үйлчилгээний хугацааг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх;
- Засаглал, зохицуулалт, дотоод зохион байгуулалт, харилцаа холбоо, мэдээллийн солилцоо, үр чадварыг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх, хязгаарлагдмал дэд бүтцийг ашиглах, удирдах зэргийг сайжруулах, Парламентын ерөнхий үр ашгийг нэмэгдүүлэх;
- Бодлогын зорилтуудын хэрэгжилтийг хянах хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнтэй тогтолцоог хэрэгжүүлэх.

¹⁵⁷STRATEGIC PLAN FOR THE FIFTH DEMOCRATIC PARLIAMENT 2014-2019, p.18

Strategic objectives are set for each main programme of Parliament. The programme structure should support the outcomes and strategic intent as set in the strategic plan. In this regard the programme structure of Parliament has largely remained unchanged since 2001. This has led to the present situation, in which the budget structure is not aligned with the strategy of Parliament. In the transition from the Fourth to the Fifth Parliament, the strategic plan, annual performance plan and budget for 2015/16 will remain in the current programme structure. However, in order to ensure better implementation, monitoring and accountability, the programme structure must be reviewed and aligned with the strategy of the Fifth Parliament.

The present budget programme for Parliament consists of the following five programmes:

Programme 1: Administration - Provide strategic leadership, institutional policy, development programmes for Members, overall management, and administrative and corporate services for Parliament's executive, management and staff.

Programme 2: Legislation and Oversight - Provide procedural and legal advice, analysis, information and research, language, content and secretarial and legislative drafting services for meetings of the National Assembly, National Council of Provinces and their committees.

Programme 3: Public and International engagement - Provide public education, information and access to support public participation, and advice and support for international engagement.

Programme 4: Members' Facilities - Provide integrated support to Members, enabling timely reimbursement to ensure smooth constituency operations away from Parliament's precincts. Provide travel, telephone and other facilities to Members of Parliament in the National Assembly and the National Council of Provinces.

Programme 5: Associated Services - Provide financial support to political parties represented in Parliament and to their leaders and constituency offices.

1.6.РУАНДА (2011-2015)

4.1. Стратеги зорилт 1: Парламентын хуулийн төсөл боловсруулах, дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх

Зорилт 1. Парламентын хуулийн төсөл боловсруулах, дүн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх

1. Парламентын гишүүд, тэдэнд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажилтнуудад зориулсан сургалт төлөвлөх, зохион явуулах;
2. Хуулийн төсөл боловсруулах, дүн шинжилгээ хийх урт удаан хугацааны уламжлалтай гадаадын парламентад танилцах аялал төлөвлөх, зохион байгуулах;
3. Хуулийн төсөл, парламентын жирийн гишүүний өргөн барьсан хуулийн төсөлд¹⁵⁸ дүн шинжилгээ хийхээс өмнө (нөхцөл байдлын) судалгаа хийх;
4. Хуулийн төсөл, парламентын жирийн гишүүний өргөн барьсан хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх;
5. Хуулийн төсөл, парламентын жирийн гишүүний өргөн барьсан хуулийн төсөлд дүн шинжилгээ хийхэд зориулагдсан хэлэлцүүлэгт олон нийтийн оролцоог хангах;
6. Хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр нөлөөг судлах;
7. Хуулийн төсөл, парламентын жирийн гишүүний өргөн барьсан хуулийн төсөлд дүн шинжилгээ хийхээс өмнөх судалгаа (экспертийн түвшинд) хийх;
8. Батлагдсан хууль тогтоомжийн цахим мэдээллийн сан байгуулах.

4.2. Стратеги зорилт 2: Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн механизмыг бэхжүүлэх

Зорилт 2. Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг төлөвлөх, үндэс суурийг бэхжүүлэх

1. Ерөнхий сайдаас хүргүүлсэн салбарын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, тодорхой стратегиудыг анхааралд авах;
2. Санхүүгийн жил бүрийн төгсгөлд үйл ажиллагааны төлөвлөгөө, тодорхой стратегийн үр дүнг үнэлэх;
3. Үндсэн хуулийн 128-р зүйл¹⁵⁹ болон Засгийн газрын үйл ажиллагааны хяналтын тухай 03/2005 дугаар органик хуулийн 9-р зүйлд заасан мэдээлэл авах бусад арга хэлбэрийг ашиглах;

¹⁵⁸Private member's bill

¹⁵⁹ARTICLE 128. MODALITIES OF EXERCISING OVERSIGHT BY THE CHAMBER OF DEPUTIES OVER GOVERNMENT ACTIVITIES

The Chamber of Deputies uses the following methods to obtain information and exercise oversight over Government activities:

1. 1°.oral questions;
2. 2°.written questions;
3. 3°.hearings before Committees;
4. 4°.commissions of inquiry;
5. 5°.interpellation.

4. Үндсэн хуулийн VIII бүлэгт заасан Комисс болон тусгай байгууллагуудын¹⁶⁰ хөтөлбөр, жилийн үйл ажиллагааны тайланд зохих дүн шинжилгээ хийх.

4.3. Стратеги зорилт 3. Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах

1. Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих сайн туршлагаудыг Парламентын гишүүд болон төрийн удирдлагын хяналтын экспертүүд хоорондын солилцооны механизмыг үр дүнтэй зохион байгуулах;
2. Нарийн мэргэжлийн салбар дахь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх, цагаар ажиллах экспертүүдийг ажиллуулах (Hiring of part-time experts);
3. Үйл ажиллагааны төлөвлөгөө, тодорхой стратегийн хэрэгжилтэд хяналт тавих;
4. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн боломжийг тэгш хүртэх боломжийг хангахын тулд жендэрийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд тогтмол хяналт тавих;
5. Гүйцэтгэлийн гэрээнд (performance contracts) хяналт, үнэлгээ хийх;
6. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хянасны үндсэн дээр Парламентаас гаргасан зөвлөмжүүдийг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулах. (Elaboration of reference documents for monitoring of recommendations made by the Parliament at the end of the exercise of oversight of Government action.)
7. Засгийн газрын үйл ажиллагаанд тавьсан хяналтын үр дүнгийн цахим мэдээллийн сан бий болгох.

Бүгд Найрамдах Руанда Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан суурь зарчмуудыг хэрэглэх механизмыг бэхжүүлэх

1. Суурь зарчмуудыг практикт хэрэглэж буй түвшинг тодорхойлох нийгэм-улс төрийн судалгаа хийх;
2. Үндсэн хуулиар баталгаажуулсан суурь зарчмуудын хэрэглээг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох зөвлөлгөөн зохион байгуулах;
3. Үндсэн хуулийн 9, 54 дүгээр зүйлд заасан суурь зарчмуудын хэрэглээнд гарсан ахиц дэвшлийг үнэлэх;
4. Улс төрийн байгууллагуудад суурь зарчмуудыг дагаж мөрдүүлэх.
5. Суурь зарчмуудын хэрэглээний цахим мэдээллийн сан бий болгох.

¹⁶⁰ARTICLE 158. NATIONAL DEFENCE AND SECURITY ORGANS

The State has the following defence and security organs:

1. 1°.Rwanda Defence Force;
2. 2°.Rwanda National Police;
3. 3°.National Intelligence and Security Service.

4.4. Стратеги зорилт 4: Парламентын олон нийттэй харилцах харилцааг сайжруулах

Зорилт 4. Нэг талаас Парламентын гишүүд нөгөө талаас иргэд, хувийн хэвшил, иргэний нийгэм ба хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй шууд харилцаа холбоо тогтоох

1. Хуулийн төсөл, хууль тогтоомж, үндэсний бодлогын асуудлаар Парламентын байнгын хороод, парламентын форум, сүлжээнүүд болон олон нийтийн бүлгүүдийн хооронд уулзалтуудыг зохион байгуулах;
2. Парламентын гишүүдийг орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн янз бүрийн бүлгүүдтэй уулзах уулзалтыг орон нутагт зохион байгуулах;
3. Олон нийтийн янз бүрийн бүлгүүдэд Парламентын зорилго зорилт, зохион байгуулалт, үйл ажиллагаа, амжилт ололтыг таниулахад дээрх бүлгүүд болон Олон нийттэй харилцах хэлтэс (Communication and Outreach Department) хоорондын уулзалтыг зохион байгуулах;
4. Парламентын сүлжээ, форумд тэднийг сурталчлах үүрэг гүйцэтгэж, Парламентын эрхэм зорилгод хүрэхэд хувь нэмрээ оруулахад нь техникийн болон материаллаг дэмжлэг үзүүлэх;
5. Байнгын хороодын хэлэлцүүлэг, нэгдсэн хуралдаанд оролцох урилгыг олон нийтэд болон иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх;
6. Сард зургаан өдөр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах;
7. Жендэрийн асуудлаар ажилладаг холбоодтой тэдгээрийн үйл ажиллагаанд учирч буй асуудлуудыг судалж, мэдээлэл авах тогтмол уулзалтуудыг зохион байгуулах.

Нэг талаас Парламентын гишүүд нөгөө талаас иргэд, хувийн хэвшил, иргэний нийгэм ба хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй шууд бус харилцаа холбоо тогтоох

1. Парламентын сар тутмын сэтгүүлийг хэвлэн нийтлэх, түгээх механизмыг сайжруулах;
2. Улсын болон хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Парламентын үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээх;
3. Парламентыг олон нийтэд сурталчлах, үйл ажиллагаа нь хүн амын тодорхой хэсэг (зорилтот бүлэг/ specified public)-т сурталчлах ажлыг төлөвлөх, зохион байгуулах;
4. Парламентын радио станцыг ажиллуулах;
5. Парламентын сар тутмын сэтгүүл, радио, телевизийн хөтөлбөр, Парламентаас зохион байгуулж буй арга хэмжээний үр нөлөөг судлахад хоёр жил тутам олон нийтийн дунд санал асуулга явуулах;
6. Парламентын вэбсайтын агуулгыг сайжруулах, шинэчлэх;
7. Парламентын шинэ номын санг байгуулах техникийн судалгаа хийх, санхүүжилтийн эх үүсвэрийг дайчлах;
8. Парламентын номын санд шинэ ном, сэтгүүл, сонин хэвлэл худалдан авах ажиллагааг үргэлжлүүлэх.

4.5. Стратеги зорилт 5: Парламентын дипломат ажиллагааг бэхжүүлэх

1. Бүсийн болон олон улсын түвшинд парламентын хоорондын уулзалтад оролцох, зохион байгуулах;
2. Парламент болон гүйцэтгэх засаглал хоорондын бүсийн болон олон улсын асуудлаарх харилцаа, холбоог бэхжүүлэх;
3. Руандагийн соёрхон баталсан олон улсын гэрээ, хэлэлцээнээс гарах үр дүнд дүн шинжилгээ хийх;
4. Руандагийн парламент ба бусад парламентуудын хооронд түншлэл, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх;
5. Руандагийн Парламент ба бусад парламент хоорондын уулзалт, айлчлалыг зохион байгуулах;
6. Бүс нутгийн улс төрийн интеграцчиллын (COMESA, EAC болон CEPGL) мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
7. Жендэрийн асуудал, Африкт хэрэгжиж буй жендэрийн стратегийн талаар Руанда болон гадаадын парламентын гишүүдийн хооронд туршлага солилцоог тогтмолжуулах;
8. Парламент хоорондын уулзалтын шийдвэр, зөвлөмжийг хянах хамтарсан хорооны хурлыг 6 сар тутам зохион байгуулах;
9. Парламентын боловсон хүчний олон улсын харилцааны салбарын мэдлэгийг бэхжүүлэх;
10. Хоёр талын парламентын бүлгийг хөгжүүлэх, бэхжүүлэх;
11. Улсын хөгжилд хилийн чанад дахь Руандагийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх.

4.6. Стратеги зорилт 6: Парламентын үйлчилгээний албыг сайжруулах

Гараар болон компьютержсэн санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн процедурын үндсэн дээр явагддаг захиргааны болон санхүүгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох (Improving the administrative and financial management system operating based on written and computerized financial and accounting procedures)

1. Захиргааны болон санхүүгийн горим журмын гарын авлагуудыг тогтмол хугацаанд шинэчлэх;
2. Захиргааны болон санхүүгийн үйлчилгээг компьютержүүлэх;
3. Парламентын үйлчилгээний чанар, үр ашгийг үнэлж, сайжруулах.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан мэдээллийн системийг бэхжүүлэх

1. Парламентын мэдээллийн технологийн сүлжээг сайжруулах;
2. Парламентын баримт бичгийн архив;
3. Парламентын баримт бичгийн электрон архив;
4. Парламентын номын сан (мэдээллийн сан)-г компьютержуулах ажлыг үргэлжлүүлэх;

5. Парламентын компьютерийн тоног төхөөрөмжийг тогтмол шинэчлэх;
6. Цахим мэдэгдлийн самбар ашиглан мэдээлэл түгээх ажлыг үргэлжлүүлэх.

Парламентын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, ажиллах нөхцөлөөр хангах

1. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын хэлбэрийг Парламентын ажлын онцлогийг харгалзан зохицуулах;
2. Сул болон шинэ орон тоонд жендэрийн эрх тэгш байдлыг харгалзан ажилд авах ажлыг зохион байгуулах;
3. Шинээр ажилд орсон ажилтнуудад танилцуулах сургалт зохион байгуулах;
4. Чадавхыг бэхжүүлэх сургалтыг орон нутагт, эсхүл гадаадад зохион байгуулах, ингэхдээ жендэрийн эрх тэгш байдлыг харгалзан үзэх.

Парламентын нийгэм-соёлын арга хэмжээ

1. Хэрэгжүүлж болох соёл, спортын арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхойлох;
2. Соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах;
3. Парламентаас спортын зориулалттай орон зай, бусад байгууламжийг байгуулах.

1.7.СЬЕРРА ЛЕОН (2016-2019)

Зорилт 1: Институцийн чадавхыг бэхжүүлэх

- 1.1. Парламентын үйлчилгээний комисс (Parliamentary Service Commission)-ын чиг үүрэг, үйл ажиллагааг жигдрүүлэх;
- 1.2. Клерк (Нарийн бичгийн дарга)-ийн албаны чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхой болгох;
- 1.3. Парламентын хараат бус байдлыг хангах (Make Parliament Autonomous);
- 1.4. Байгууллагын чадавхыг бэхжүүлэх: Захиргаа ба удирдлага; хууль тогтоох, хянан шалгах, төлөөллийн чиг үүргийн хүрээнд;
- 1.5. Парламентын Тамгын газарт жендэрийн асуудлыг бодлого, үйл ажиллагаанд тусгах;
- 1.6. Хандивлагчдын зохицуулалт, түншлэлийн харилцааг сайжруулах (Improve Donor Coordination and Partner Relations);
- 1.7. “Цаасгүй Парламент”-д шилжихийн тулд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, гүнзгийрүүлэх.

Зорилт 2: Хууль тогтоох чадавхыг бэхжүүлэх

- 2.1. Парламентын гишүүдийн хууль тогтоох үүрэг ролийг бэхжүүлэхийн тулд Парламентын дэгийг шинэчлэх;
- 2.2. Парламентын хороодын болон Хууль зүйн хорооны хоорондын харилцааг боловсронгуй болгох;
- 2.3. Парламентын гишүүд, ажилтнуудын хууль тогтоох үйл явц болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах чадавхыг бэхжүүлэх;

- 2.4. Хууль тогтоох асуудалтай холбоотойгоор судалгааны чадавхыг бэхжүүлэх (хууль эрх зүйн хэлтэс болон судалгааны албан хаагчдад тогтмол сургалт явуулах)
- 2.5. Нээлттэй ба ил тод хууль тогтоох үйл явцыг бий болгох;
- 2.6. Парламентын хууль эрх зүйн зөвлөл (Office of Parliamentary Legal Counsel) байгуулах.

Зорилт 3: Хяналтын чадавхыг бэхжүүлэх

- 3.1. Хяналтын хорооны үйл ажиллагааны дүрэм, журмыг боловсруулах;
- 3.2. Хороодын үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх;
 - 3.2.1. Парламентаас Засгийн газарт өгсөн үүрэг, Засгийн газрын амлалтад хяналт тавих хороо байгуулах (Create a Government Assurances Committee);
 - 3.2.2. Төрийн хариуцлага, ил тод байдал ба санхүүгийн хороодыг бэхжүүлэх (Public Accounts, Transparency and Finance Committees);
 - 3.2.3. Эрүүл мэндийн байнгын хороог бэхжүүлэх;
 - 3.2.4. Байгалийн нөөц баялгийн байнгын хороог бэхжүүлэх.
- 3.3. Хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд судалгааны чадавхыг бэхжүүлэх;
- 3.4. Парламентын төсвийн алба (Parliamentary Budget Office (PBO)) байгуулах.

Зорилт 4: Парламентыг нээлттэй болгох (Make Parliament Accessible, open and Representative)

- 4.1. Парламентын гишүүдийн тойрог дахь оффисуудыг байгуулах (Set up Constituency Offices)¹⁶¹;
- 4.2. Хороодын олон нийттэй харилцах, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх;
- 4.3. Парламент дахь хэвлэл мэдээллийн урсгалыг боловсронгуй болгох (Streamline Media set up in Parliament);
- 4.4. Хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудтай холбоо тогтоох;
- 4.5. Дээд боловсролын түвшинд иргэний боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 4.6. Тойрогт ажиллах төсөв (Хөгжүүлэх сан)-ийг зарцуулах, ашиглах тодорхой дүрэм, журмыг боловсруулах (Develop Clear Rules and Procedures for Constituency Development Funds).

¹⁶¹4.1. Set up Constituency Offices

Constituency Offices play two vital roles. First, they enable the public to become active citizens and take part in parliamentary activities. Second and most importantly, they provide avenues and opportunities for MPs to interact with their constituents. Services that give effect to this are direct interaction with MPs and the opportunity to lobby representatives, report from MPs and advise on how to access services from both public and private sector establishments. They also offer assistance with challenges that face local communities and in participating in the processes of Parliament, such as preparing submissions or drawing up and presenting petitions. MPs also attend Committee meetings, so that they can convey information about what happens there to the public.

Getting citizens to take an interest in and participate in governance processes augers well for development, as development then becomes all inclusive. When citizens participate in governance, they do not feel left out and are more willing to cooperate with governance institutions as they work to deliver goods and services. The setting up of constituency offices under this strategic plan is one of the ways through which Parliament hopes to take representation and participation to the doorstep of the people. These offices will serve as a field office of the Parliament of Sierra Leone, where citizens could go for information on parliamentary activities as well as channel their concerns to their Members of Parliament.

1.8.УГАНДА (2014-2018)

Стратеги зорилт 1. Парламентын бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадавхыг нь бэхжүүлэх

1. Хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, чанартай хууль тогтоомж боловсруулж батлах, үр дүнтэй төсөвлөх, олон намын парламентын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр Парламентын гишүүд болон ажилтнуудад үйлчилгээ үзүүлэх хүчтэй механизмыг бий болгох; (Build a strong institutional mechanism for delivery of services to MPs and staff for effective oversight, quality legislation and appropriation, and consolidation of multi-party parliamentary system)
2. Парламентын Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;
3. МХХТ-ийн стратеги, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;
4. Парламентын чадавхыг бэхжүүлэхэд Парламент судлалын хүрээлэнг дэмжих;
5. Парламент дахь намын албадад дэмжлэг үзүүлэх;
6. Хороодод хууль тогтоомж, төрийн бодлого боловсруулах, улсын төсөв, хөндлөнгийн аудитын тайлан хэлэлцэх чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
7. 2016/17 онд 10 дахь парламентад танилцуулах хөтөлбөрийг зохион байгуулна.

Стратеги зорилт 2. Парламентын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх - хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих

1. ИНБ-уудын мэдээллийн сан үүсгэж, шинэчлэх, Парламенттай харилцах харилцааг бэхжүүлэх;
2. Парламентын чиг үүрэг, эрх хэмжээний талаарх иргэний боловсролын хөтөлбөрөөр дамжуулан иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэлтэй оролцох чадавхыг бий болгох;
3. Хэрэглэгчдэд хялбар, энгийн, ойлгомжтой (user-friendly) хэвлэл, мэдээллээр дамжуулан олон нийтийн мэдээллийн үйлчилгээг бэхжүүлэх;
4. Парламентын олон нийтэд чиглэсэн хөтөлбөрийг нэвтрүүлж, дэмжлэг үзүүлэх;
5. Парламентын ажилд Залуучуудын оролцоог хангахад чиглэсэн хөтөлбөрийг бий болгох;
6. Хороод ажлын явц байдалтай газар дээр нь очиж танилцах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх;
7. Парламентын гишүүдийн үүрэг ролийн тухай Парламент болон олон нийтэд санал солилцох механизмыг бий болгох;
8. Тойргийн ажил (constituency work)-д дэмжлэг үзүүлэх;
9. Орон нутгийн засаг захиргаа, Парламент хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх.

Стратеги зорилт 3. Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнтэй тогтолцоог бий болгох замаар Парламентын хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх

1. Дотоодын мониторинг, үйл ажиллагааны тогтолцоог сайжруулж, хэрэгжүүлэх, Парламентын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ хийх (Парламентын өөрийн үнэлгээ/Parliamentary Self-Assessment Tool);
2. Төсөв боловсруулах, гүйцэтгэл, тайлагнах нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох;
3. Үйл ажиллагааны ХШҮ-ний механизмыг бий болгож, дэмжих;
4. Хуулийн төслийн явцыг хянах системийг нэвтрүүлэх (Operationalize bill tracking system);
5. Парламентын бусад үйл ажиллагаа болох өргөдөл гомдол, асуулга, санал, зөвлөмж зэрэгт хяналт тавих механизм бий болгох;
6. Жил бүрийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан гаргаж Парламентын комисст хүргүүлэх.

Стратеги зорилт 4. Үндэсний хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Парламентын шударга, тогтвортой оролцоог хангах

1. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр зэргийн биелэлтийг хянахад Парламентын оролцоог сайжруулах;
2. Хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд олон талт асуудлуудыг бодлого, үйл ажиллагаанд тусгах;
3. Төсвийн мөчлөг (процессууд) дэх Парламентын хяналтыг сайжруулах;
4. Хороодын үйл ажиллагаанд хийдэл байгаа бол арилгахад дэмжлэг үзүүлэх; (Support all Committees to clear backlogs where they exist)
5. Төсвийн хөрөнгийн үр өгөөж (VFM) болон орлого багатай иргэдэд чиглэсэн тэтгэмжийн бодлогыг хэрэгжүүлэхэд Парламентын хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх.

Стратеги зорилт 5. Угандагийн гадаад бодлогын хүрээнд Парламентын гадаад харилцаа, олон улсын оролцоог сайжруулах

1. Бүс нутаг, тив болон олон улсын ажиллагаанд Парламентын гүйцэтгэх үүргийг сайжруулах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх;
2. Олон улсын парламентын форумд зохистой оролцох Парламентын гишүүдийн чадавхыг сайжруулах;
3. Парламентын туршлага судлах аяллуудыг ивээн тэтгэх (Sponsor international Parliamentary benchmarking trips);
4. Парламентад зочилж буй төлөөлөгчдийг хянах системийг бий болгох (Establish a system of tracking incoming delegations to Parliament);
5. Парламентын гадаад томилолт, айлчлалд хяналт тавьж, төлөөлөгчийн айлчлалын үр дүнд жил бүр үнэлгээ хийх (Monitors outgoing delegations facilitated by Parliament annually and the assess the outcomes of such delegations' visits);

6. Гэрээ, хэлэлцээр, протоколыг хянах, бүртгэх механизмыг бий болгох (Establish a mechanism to track treaties, agreements conventions and protocols);

Стратеги зорилт 6. Үр ашиг, бүтээмжийг сайжруулахад Парламент (танхим, хорооны өрөө, машины зогсоол, оффис гэх мэт)-ын барилга байгууламжийг өргөтгөх

1. Одоогийн Парламентын байрыг өргөтгөх;
2. Парламентын шинэ байрыг барьж байгуулах, энэхүү Парламентын Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд нөөц боломжийг дайчлах.

1.9.ПАКИСТАН (2014-2018)

Зорилт 1. Хууль тогтоомжтой холбоотой бүх асуудлыг Пакистаны ард түмэнд үр нөлөөтэй, үр ашигтай байхаар бэхжүүлэх

- Парламентын судалгаа, номын сангийн хууль тогтоомжийн үйл явцыг дэмжих чадвар, чадавхыг дээшлүүлэх;
- Дотоод болон олон улсын харилцааг сайжруулах;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зөвлөл байгуулах.

Зорилт 2. Ил тод байдал давамгайлж, цаг хугацаа, нөөцийн зохистой ашиглалтад хариуцлага хүлээлгэх боломжтой байхаар, ялангуяа Парламентын Хороодын түвшинд хяналтыг бүх цаг үеийн турш, бүхий л түвшинд хэрэгжүүлэх

- Байнгын хороодыг бүх талаараа дэмжиж ажиллах;
- Хорооны дарга нарын зөвлөл нь давамжтай уулзаж, танхимын зангилаа төвийн үүргийг гүйцэтгэдэг байх;
- Парламентын номын сан болон мэдээллийн менежментийн чадавхыг хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сайжруулах.

Зорилт 3. Ассамблейн төлөөллийн чиг үүргийг сайжруулах замаар Ассамблейн шударга байдлыг сахиж, илүү мэдээлэлтэй, сонгогч, төлөөлж буй тойрогуудынхаа хүндлэлийг хүлээх

- Олон нийт, Парламентын хоорондох харилцааг бэхжүүлэх; (Eliminate the disconnect between the public and the parliament)
- Олон нийтийн хэлэлцүүлэг, ТХЗ-ийн ажлын хэсэг, Найрамдлын бүлэг, Эмэгтэй гишүүдийн санал, санаачилга, Залуучуудын парламентын форум зэрэг хороодын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний байгууллага, тинк танкуудтай холбоо тогтоох замаар үндэсний болон олон улсын хэмжээнд олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлэх.

Зорилт 4. Танхимын бүхий л чиг үүрэг, үйл ажиллагааг үр ашигтай болгох;

- Албан хаагчдад үйлчлэх дүрмийн хэрэгжилтийг хангах;
- Хүний нөөцийн хөгжил, менежментийн нэгжийг байгуулах;
- ТУН (PMU)-ийн хүрээнд Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжийг байгуулах;

- PIPS (Пакистаны Парламентын үйлчилгээний хүрээлэн)-г бэхжүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх замаар хүний нөөцийг зохион байгуулж, сурах (Organize and train human resources by strengthening PIPS and establishing a cadre of Master Trainers).

Зорилт 5. Мэдээлэл Харилцаа Холбоо, Технологи (МХТ)-д бүтцийн шинэчлэл хийх замаар уламжлалт горимоос автоматжуулсан Е-парламентад (цахим парламентад) шилжих

- МХХТ-ийн стратегийн хэрэгжилт, Парламентын Тамгын газрын ажилтнуудыг автоматжуулсан цахим парламентад шилжих шилжилтийг жигдрүүлэхэд зохистой сургалт, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдалд хяналт тавих

Зорилт 6. PIPS (Пакистаны Парламентын үйлчилгээний хүрээлэн)-г Үндэсний парламентын гишүүд болон албан хаагчид, орон нутгийн 4 парламентад зориулсан сургалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх хүрээлэн болгон бэхжүүлэх

- Чанартай сургалт, найдвартай судалгаа явуулах дотоод чадавхыг бий болгож, үндэсний болон олон улсын хэмжээнд тангтай харилцаа холбоог өргөжүүлэх.

1.10.БУТАН (2014-2018)

Стратеги зорилт 1. Үндэсний Ассамблейн Тамгын газрын чадавхыг бэхжүүлэх

- 1.1. Хүний нөөцийн чадавхыг сайжруулах;
- 1.2. Ажилтнуудын хөгжлийн хэрэгцээний үнэлгээ ба гүйцэтгэх төлөвлөгөө;
- 1.3. Тамгын газрын удирдлага, зохион байгуулалтын чадавхыг бэхжүүлэх;
- 1.4. Олон улсын парламентын байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг сайжруулах;
- 1.5. Тамгын газрыг бие даасан болгоход чиглэн ажиллах;
- 1.6. Ажиллах нөхцөл, ажлын өрөө, барилга байгууламжаар хангах;
- 1.7. Номын санг бэхжүүлэх;
- 1.8. Парламентын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад мэргэжил дээшлүүлэх сургалт тогтмол зохион явуулах;
- 1.9. Үндэсний Ассамблейд Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах;
- 1.10. Парламентын сургалтын төв.

Стратеги зорилт 2. Үндэсний Ассамблейн хууль тогтоох чадавх, үйл ажиллагааг сайжруулах

- 2.1. Дэгийг шинэчлэх;
- 2.2. Тамгын газрын хууль зүйн дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх;
- 2.3. Парламентын гишүүдэд хууль тогтоох үйл ажиллагааны асуудлаар сургалт явуулах

- 2.4. Парламентын хороодыг бэхжүүлэх;
- 2.5. Нээлттэй, ил тод хууль тогтоох үйл ажиллагааг бий болгох;
- 2.6. Хууль тогтоомжийн асуудлаар хууль тогтоох байгууллага болон Засгийн газрын харилцааг хангасан тогтолцоог боловсронгуй болгох.

Стратеги зорилт 3. Үндэсний Ассамблейн хяналт тавих чадавхыг нэмэгдүүлэх

- 3.1. Өнөөгийн хяналт тавих механизмыг бэхжүүлж, гишүүдэд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулах;
- 3.2. Хяналтын чиг үүргийн үр дүнг дээшлүүлэхэд Парламентын байнгын хороодыг бэхжүүлэх;
- 3.3. Санхүүгийн хяналтыг дээшлүүлэхэд гишүүд болон Тамгын газрын ажилтнуудын чадавхыг сайжруулах;
- 3.4. Хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Засгийн газартай хамтран ажиллах;
- 3.5. Судалгаа, шинжилгээний үйлчилгээг бэхжүүлэх.

Стратеги зорилт 4. Үндэсний Ассамблейн төлөөллийн болон олон нийттэй харилцах чадавхыг нэмэгдүүлэх

- 4.1. Хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийт мэдээлэлтэй оролцох, хэлэлцүүлэг өрнүүлэх соёлыг бий болгох;
- 4.2. Үндэсний Ассамблейн эмэгтэй гишүүдийг чадавхжуулах;
- 4.3. Төлөөлөл болон манлайллаар сургалт зохион явуулах;
- 4.4. Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай ажиллах механизмыг сайжруулах;
- 4.5. Сонгогчдын эрх ашгийг төлөөлөхөд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах;
- 4.6. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, харилцах;
- 4.7. Парламентад бие даасан радио, телевизийн станц байгуулах;
- 4.8. Цахим хуудсыг ашиглахад хялбар, мэдээлэл сайтай, интерактив болгох, шинэчлэх;
- 4.9. Залуучуудын боловсрол ба оролцоо;
- 4.10. Парламентын музей ба Бутаны ардчилалд хүрсэн зам-баримтат кино.

1.11.КИРГИЗ (2016-2021)

3.1. Төлөөллийн үйл ажиллагаа

1. Улс орны хөгжлийн стратегийн хэтийн төлөвийн талаар нэгдсэн байр суурийг бий болгоход фракц (бүлэг) хоорондын харилцан ажиллах харилцааны эрх зүйн болон институцийн механизмыг бий болгох;
2. Парламентад суудал аваагүй намуудад саналаа өгсөн сонгогчдын саналыг харгалзан тооцох механизмыг бий болгох;
3. Бүлгүүдийн үйл ажиллагаа, намын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас хэрэгжүүлж буй ажил, Парламентын баталсан хууль зэргийг сонгогчид хэрхэн үнэлж байгааг тогтоох механизм,

эргэх холбоог боловсруулж, нэвтрүүлэх. Бүлэг сонгогчидтой тогтмол харилцах, бүлэг үр дүнг тайлагнах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх тогтолцоог бий болгох. Парламент болон бүлгүүдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хүргэх цагийг нэмэгдүүлэх. Бүлгүүдийн байнгын төлөөлөгчийн газруудыг бүс нутгуудад байгуулах;

4. Сонгуулийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, намыг бэхжүүлэх, намын жагсаалтын чанарт хариуцлагыг сайжруулах, намын нэрсийн жагсаалтыг сайжруулах, гишүүдийн корпусын чадавхыг (укрепление потенциала депутатского корпуса) бэхжүүлэхэд чиглэсэн шинэ хуулийн төслийг боловсруулан батлах;
5. Бүлгүүдийн ажлын албадын тухай журам, тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг үнэлэх шалгуур, Тамгын газрын ажилтнуудад тавигдах мэргэшлийн шаардлагыг боловсруулж, хэрэгжүүлэх.

3.2. Хууль тогтоох үйл ажиллагаа

1. Дунд болон богино хугацааны зорилтуудыг хэлэлцэж батлах, улс орны хөгжилд стратегийн алсын харааг тодорхойлоход Парламент гол үүргийг гүйцэтгэдэг болох. Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг улс орны хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх практикийг нэвтрүүлэх;
2. Засгийн газартай хамтран холбогдох салбарын хөгжлийг богино болон урт хугацааны тэргүүлэх чиглэлийг харгалзан хууль тогтоох ажиллагааг тодорхой төлөвлөх. Холбогдох салбарт хууль батлах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тооцоолох (таамаглах) практикийг Парламентын үйл ажиллагаанд нэвтрүүлэх. Хүлээгдэж буй үйл явдлыг урьдчилан таамаглах, хууль шаардлагатай эсэхэд бодитой дүгнэлт гаргахыг Засгийн газарт үүрэг өгөх;
3. Хууль эрх зүйн болон төрөлжсөн мэргэжлийн дүн шинжилгээ, хууль зүйн техниктэй холбоотой мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. Одоо дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг тогтмол хянах (хууль тогтоомжийг эргэн хянаж үнэлэх/ретроспективная оценка законодательства) тогтолцоог бий болгож, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалыг хэрэглэх байдлаар батлагдаж буй хууль тогтоомжийн чанарыг сайжруулах;
4. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг гагцхүү мэргэшсэн мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлж, тэдгээрийн мэргэшүүлэн хөгжүүлэх боломжийг олгосон шаардагдах хууль эрх зүйн зохицуулалт, бүтэц зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх;
5. Хэлэлцэж буй хуулийн төсөлд олон нийтээс санал авах, санаа бодлыг тусгах ажлыг сайжруулах. Олон нийттэй зөвлөлдөх нэгдсэн арга барилыг боловсруулах. Хуулийн төслийг боловсруулахаас

өмнө олон нийтийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, түүнчлэн аливаа хууль тогтоомжийн хэрэгцээг шаардлагыг тодорхойлоход олон нийтийн оролцоог хангах.

3.3. Хяналтын үйл ажиллагаа

1. Парламентын хяналтын зорилго, объект, хэлбэрийг тодорхой зааж өгсөн дүрэм, журам боловсруулах. Бүгд найрамдах улсын төсвийн гүйцэтгэлийн биелэлт үр дүнтэй байдлыг шалгах шалгуурыг боловсруулж хэрэгжүүлэх. Тооцооны танхим (Счетная палата)-ын Парламентад хүргүүлдэг тайланд Парламентаас баталсан улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүд болон төсвийн зарцуулалтын нийцэл/үл нийцлийн талаар тусгуулах шаардлага тавих;
2. Гишүүний асуулга, парламентын хэлэлцүүлгийн дэг, “Засгийн газрын цаг/засгийн газрын өдөр” (Ерөнхий сайдын мэдээллийн цаг), парламентын мөрдөн шалгах (парламентского расследования) зэрэг процедурын стандарт, парламентын хяналтын төлөвлөлтийн төлөвлөгөө боловсруулж, үйл ажиллагааны нарийвчилсан арга зүйн журам боловсруулж, нэвтрүүлэх;
3. Хяналтын төлөвлөлтийн механизмыг нэвтрүүлж, Парламентын хяналтад хороодоор тэргүүлэх үүргийг гүйцэтгүүлэх. Парламентын хяналтад бүлгүүдийн эрх үүргийн/бүрэн эрхийн хязгаарыг тогтоох. Парламентад ажлаа хариуцан тайлагнадаг төрийн байгууллагууд (тайлагнах давтамж, асуудлын хамрах хүрээ, үнэлгээний шалгуур гэх мэт)-ын жил бүрийн тайлан гаргах шалгуур, хэлбэрийг нарийвчлан тогтоох;
4. Парламентын аппарат нь парламентын хяналттай холбоотой ажлын тасралтгүй, тууштай, үр дүнтэй байдлыг хангах бөгөөд давхардал, давтан хяналтыг арилгана. Үүний тулд Аппарат дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - тодорхой асуудлаар хариуцлагатай шийдвэр гаргах, байр суурь илэрхийлэхэд шаардлагатай мэдээллийг авах, цуглуулах;
 - хүлээн авсан мэдээллийн урьдчилсан боловсруулалт хийх;
 - хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх;
 - тодорхой асуудлаар байр суурь болгох;
 - хууль эрх зүйн тогтолцоог тогтмол хянах;
 - батлагдсан хуулийг хэрэгжүүлэх талаарх мэдээллийг бэлтгэх;
 - Парламентын хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх талаарх гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны урьдчилсан үнэлгээ.

3.4. Дүн шинжилгээний үйл ажиллагаа

1. Парламентын хороодын эрхэлсэн салбарын хүрээнд төрийн бодлогыг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх. Хороод нь салбарын хөгжлийн асуудлуудыг тэргүүлэх чиглэлийг тодорхойлох шалгуурыг бий болгох хэрэгтэй. Холбогдох хороод (Профильные комитеты) нь хангалттай нөөц (хууль эрх зүйн, институцийн, хүний нөөцийн, мэдээлэл г.м.)-р хангагдсан байна;
2. Аппаратын ажилтнуудын аналитик, судалгааны ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах. Парламентын аппаратын ажилтнуудад зориулж улс орны хөгжлийн гол асуудлуудын талаар арга зүйн семинарыг тогтмол зохион байгуулах практикийг нэвтрүүлэх;
3. Парламентын аппаратын дүн шинжилгээний үйл ажиллагаанд оролцдог ажилтнуудад материаллаг болон материаллаг бус урамшуулал олгох тогтолцоог нэвтрүүлж, улирлын ажлын үр дүнг үнэлэхэд тус ажлыг зайлшгүй тусгах. Парламентын аппаратын аналитик, дүн шинжилгээний ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах;
4. Одоогийн Судалгааны Төвийг Парламентын Хөгжлийн Төв болгон зохион байгуулж, түүний түр хугацааны хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр шинжээчдийг ажиллуулах эрх мэдлийг өргөтгөх;
5. Парламентын дотоод сүлжээнд дүн шинжилгээний ажлууд (VIP-net)-ыг нийтлэх. Удирдлага нь ажилтнуудад урамшуулал олгохдоо дээрх нийтэлсэн ажлуудыг харгалзан үзэх ба давхардсан эсэхэд хяналт тавина. Шинжээчдийн хэвтээ харилцааны дотоод форумыг бий болгох.

3.5. Олон улсын үйл ажиллагаа

1. Киргиз Улсын гадаад бодлогын зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. Хууль тогтоох байгууллагын хүрээнд энэ нь орчин үеийн улс төрийн сэтгэлгээг бий болгох, нийцүүлэх, Парламентын хяналтыг тогтолцоог бий болгоход чиглэгдэнэ;
2. Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд парламентын гишүүдийн олон талт оролцоог хангах: дэлхийн хэмжээнд (ЮНЕСКО, Олон улсын парламентын холбоо) болон бүсийн хэмжээнд (PACE, IPA CIS, OSCE PA);
3. Парламентын болон гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог засгийн газрын байгууллагуудтай хамтран ажиллах харилцааны зохицуулалтын механизмыг бий болгох.

1.12.СОЛОМОНЫ АРЛУУД (2017-2021)**1. Парламентын улсад үйлчлэх чадавхыг хөгжүүлэх; Парламентын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх**

- 1.1. Парламентын бие даасан, хараат бус байдал;
- 1.2. Парламентын орчны өөрчлөлтийн талаарх Үндэсний парламентын албаны үйлчилгээг сайжруулах;
- 1.3. Хүний нөөцийг бэхжүүлэх;
- 1.4. Парламентын дэд бүтцийг хөгжүүлэх;
- 1.5. Цахим парламент байгуулах;
- 1.6. Парламентын үйл ажиллагааны үр дүнтэй тайлагнал;
- 1.7. Парламентын гишүүдийн чадавх, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх;
- 1.8. Бүс нутгийн болон олон улсын харилцаа холбоог хөгжүүлэх, дэмжих;
- 1.9. Парламентын Санхүүгийн удирдлагын менежментийг бэхжүүлэх (Strengthen the Parliament Office Finance Management);
- 1.10. Ёс зүйн дүрэм;
- 1.11. Парламентын үйл явдлын хуанли;
- 1.12. Парламентын жендэрийн бодлого.

2. Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгох замаар хууль тогтоомжийн чанарыг сайжруулах

- 2.1. Хууль тогтоох үйл явцын хуваарь;
- 2.2. Парламентын хууль тогтоомжийн төслийг боловсруулах чадавхыг бэхжүүлэх;
- 2.3. Спикерийн зөвлөл байгуулах хувилбаруудыг судлах;
- 2.4. Хууль тогтоох процессийг зөвлөлдөх;
- 2.5. Хуулийн төслийн үр нөлөөг судлах;
- 2.6. Хууль тогтоох үйл явцад оролцох гишүүдийн чадавхыг нэмэгдүүлэх;
- 2.7. Дэгийг шинэчлэн боловсруулах;
- 2.8. Жендэрийн асуудлыг хууль тогтоомж, бодлогод тусгах.

3. Парламентын Засгийн газарт үр дүнтэй хяналт тавих чадавхыг сайжруулах

- 3.1. Парламентын хороодыг бэхжүүлэх;
- 3.2. Үр дүнтэй төсвийн хяналт;
- 3.3. Номын сан, судалгааны үйлчилгээг сайжруулах замаар Парламентын хяналтын чадавхыг нэмэгдүүлэх;
- 3.4. Бие даасан хяналтын байгууллагатай харилцах;
- 3.5. Хяналт, төлөөллийн чиг үүрэгтэй холбоотойгоор жендэрийн асуудлыг бодлого, хууль тогтоомжид тусгах.

4. Парламентын боловсрол, олон нийттэй харилцах болон гишүүдийн төлөөллийн чиг үүргийг сайжруулах

- 4.1. Олон нийтийн харилцаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
- 4.2. Парламентын ажилд залуучуудыг оролцуулах;
- 4.3. Парламент болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хоорондын харилцааны ач холбогдлыг таньж мэдэх;

- 4.4. Парламентад хэрэглэгчдэд ээлтэй хэвлэл мэдээллийг боловсруулах, шинэчлэх;
- 4.5. Парламентын төлөөллийн чиг үүргийг нэмэгдүүлэх хувилбаруудыг судлах;
- 4.6. Жендэрийн асуудлыг хууль, бодлогод тусгах;
- 4.7. Орон нутгийн хууль тогтоох байгууллагуудтай холбоо тогтоох.

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү судалгаанд Австрали, ИБУИНХУ, Молдова, Шинэ Зеланд Улсын парламентын ажлын албадын стратеги зорилтыг авч үзлээ.

1. Парламентын үндсэн 3 чиг үүрэг болох хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөх чиг үүрэг болон парламентын тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах үүргийн хүрээнд дээрх 4 улсын парламентын ажлын албадын стратеги төлөвлөгөөг харьцуулан, нийтлэг болон онцлог зорилтуудыг түүвэрлэв.
2. Парламентын ажлын албадын стратеги төлөвлөгөө

1. Парламентын үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нийтлэг болон онцлог стратеги зорилтууд

Хууль тогтоох болон хянан шалгах чиг үүргийн хүрээнд

Нийтлэг

1. Парламентын гишүүдийг цаг үеийн асуудлаар, нэгдсэн болон байнгын, түр хороодын хуралдаанд шаардлагатай үнэн зөв, мэдээ мэдээлэл, санал зөвлөмжөөр хангаж ажиллах;
2. Хуулийн төсөл болон парламентаар хэлэлцэх аливаа асуудал судалгаа шинжилгээ, баримт нотолгоон дээр үндэслэсэн байх;
3. Хууль батлагдахаас өмнө болон батлагдсаны дараа нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг судлах, үнэлгээ хийх;
4. Парламентын гишүүдэд шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын албаны ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх, тэдний чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;
5. Парламентын хяналт шалгалтын чадавхыг бэхжүүлэх, хяналт шалгалтын үйл явцыг тодорхой болгох;
6. Парламентын үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ мэдээллийг парламентын үндсэн веб хуудсан дээр байршуулж байх;
7. Парламентын үндсэн интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, сүлжээний хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлгөөнт интернэт сүлжээний технологийг үйлчилгээндээ ашиглах;

8. Парламентын гишүүд, тэдгээрийн туслах ажилтнууд, ажлын албаны ажилтнуудыг өндөр хурд бүхий, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах, хэрхэн ашиглах сургалт зохион байгуулж байх;
9. Мэдээлэл түгээлт, солилцоог хялбарчлах, цахимжуулах;

Онцлог

1. Хууль зүйн техникийн гарын авлагыг боловсруулах;
2. Ажлын албаны ажилтнуудад шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал бодлоо илэрхийлэх, хувь нэмрээ оруулах боломжоор нь хангаж ажиллах;
3. Парламентаас гадна эрдэмтэн, судлаачидтай хамтарч ажиллах;
4. Парламентын гишүүдийн болон парламентын ажлын албаны төсөв, түүний зарцуулалтыг цаг хугацаанд нь тайлагнах, төсвөө хэрхэн зөв хянаж, зарцуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, төсөв, санхүүгийн тайлангаа интернэт сүлжээгээр хүлээн авах, хянах боломжийг олгох;

Төлөөлөх чиг үүргийн хүрээнд

Нийтлэг

1. Парламентын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан, тэдний сонирхож буй асуудлаар мэдээлэл өгч, ард иргэдийн санал бодлыг сонсож, хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах;
2. Парламентын цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр үйл ажиллагаагаа мэдээлж байх;
3. Парламентын цахим хуудас, парламентын үйл ажиллагааг сурталчлах парламентын дэргэдэх болон орон нутагт байрлах төвүүдээр дамжуулан иргэдийн санал бодлыг сонсох, үйл ажиллагаандаа тусгах байдлаар хамтарч ажиллах;
4. Иргэдийн парламенттай харилцах харилцааг нэмэгдүүлэх зорилгоор парламентын ордноор зочилж, нэгдсэн болон хороодын хуралдааны үйл явцтай танилцах боломжоор хангах;

Онцлог

1. Парламентын үйл ажиллагааг сурталчилсан, таниулсан нээлттэй өдөрлөг зохион байгуулах, иргэд олон нийтийг парламентын удирдлагуудтай уулзах боломжоор хангах;
2. Залуучууд, өсвөр үеийнхэн, бага орлоготой иргэд нь парламентын үйл ажиллагаа, ач холбогдлын талаар мэдээлэл хомс байдагтай холбоотой тэдэнд мэдээллийг ойлгомжтой, хялбар байдлаар хүргэхийг зорих;
3. Парламентын боловсролыг түгээх аргыг өргөжүүлж, сургуулийн насны хүүхдүүдийг парламенттай, түүний үйл ажиллагаатай нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан танилцуулах;
4. Ард иргэдэд парламентын талаарх мэдээ мэдээллийг дүрс бичлэгээр, хэвлэмэл байдлаар, инфографикаар гэх мэтчилэн олон төрлөөр түгээх;

Парламентын тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах чиг үүргийн хүрээнд

Нийтлэг

1. Ажлын алба нь ажил үүргээ чанартай хийж гүйцэтгэх үүднээс ажлын ачаалал болон нөөц бололцоогоо хянаж, уялдуулж байх;
2. Дотооддоо холбоо харилцаа, мэдээлэл солилцоогоо сайжруулж, нөөц бололцоогоо ашиглан, ажлаа жигд хуваарилан чанартай гүйцэтгэх;
3. Ажилтнуудад мэдээ мэдээлэл хайх, хадгалах систем нь хэрэглэхэд хялбар, боловсруулсан мэдээллээ байрлуулах, эргээд ашиглах боломжтой, үр дүнтэй байхад анхаарч ажиллах;
4. Ажлын алба нь ажилтнуудаа мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх болон эрсдэлийг тодорхойлох, даван гарах байгууллагын чадавхыг бий болгож ажиллах;
5. Парламентын ордны барилга байгууламжийн аюулгүй байдлыг ханган, засвар үйлчилгээг тогтмол хийх;

Онцлог

1. Ил тод, нээлттэй өрсөлдөөнт шалгалтаар ажилтнуудыг шалгаруулж авах;
2. Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад зориулсан гарын авлагыг хэвлүүлж, тогтмол шинэчилж байх;
3. Парламент дээр дадлага хийх дадлагын журмыг боловсруулж ажиллах.

ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1.АВСТРАЛИ

Хууль тогтоох Ассамблейн ажлын албаны стратеги төлөвлөгөө¹⁶²:

- Ардчилсан институт болох Ассамблейд дэмжлэг үзүүлж ажиллах
Ажлын алба нь Ассамблей, түүний хороодод хууль тогтоох, хяналт тавих, ард иргэдийг төлөөлөх үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах;
- Ассамблейн гишүүдэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, зөвлөгөө өгөх
Ассамблейн гишүүдэд Ассамблейн болон хороодын, түүнчлэн сонгогдсон тойргийнхоо ажилд идэвхтэй оролцоход нь чанартай, цаг үетэйгээ нийцсэн зөвлөх болон туслах үйлчилгээ үзүүлэх;
- Байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэх
Оновчтой, зөв шийдвэр гаргаж, дотооддоо холбоо харилцаа, мэдээлэл солилцоогоо сайжруулж, нөөц бололцоогоо ашиглан, ажлаа жигд хуваарилан хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа чанартай гүйцэтгэх (түргэн хугацаанд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлж, зөвлөгөө мэдээллээр хангах)

¹⁶²https://www.parliament.act.gov.au/_data/assets/pdf_file/0006/1195737/Strategic-Plan-Office-of-the-Legislative-Assembly-2018-2022.pdf

Зорилт 1-ийн хүрээнд:

- Ассамблей нь хуралдааны дэгээ өөрчлөн, шинэчлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд ажлын алба нь зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
- Хуралдааны дэгд өөрчлөлт оруулах тохиолдолд ажлын алба нь парламентын үйл ажиллагаа үр дүнтэй, хэвийн явагдахад онцгойлон анхаарч энэ талаар санал зөвлөмж өгөх;
- Гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой Ассамблейн ордны багтаамжийг харгалзан гишүүд, тэдгээрийн ажилтнууд, ажлын албаны ажилтнуудад өрөө тасалгааг хүртээмжтэй, зөв хуваарилах;
- Цахим орчны хэрэглээ, цахим сүлжээ, ялангуяа нийгмийн сүлжээ, хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн хэрэглээ өссөнтэй холбоотойгоор иргэд парламентын үйл ажиллагааг сонирхох, үйл явцад нь анхаарал хандуулах байдал нэмэгдэж байгаа тул тэдний санал бодлыг сонсох, үйл ажиллагаандаа тусгах байдлаар хамтарч ажиллах;
- Иргэд, олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаагаа тухайн үеийн чиг хандлагаас илүүтэйгээр Ассамблейн ардчилсан үзэл баримтлал, үйл явцтай уялдуулах;
- Ассамблей болон гишүүдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;
- Ажлын алба нь байнгын хувьсан өөрчлөгдөж буй орчин нөхцөлд аюулгүй байдлаа (биет/бодит аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал болон кибер аюулгүй байдал) ханган, болзошгүй аюул нүүрлэхээс сэргийлэх бодлого болон аюул нүүрлэсэн тохиолдолд хэрэгжүүлэх оновчтой, тохирсон арга хэмжээг боловсруулж ажиллах;
- Ажлын алба нь Ассамблейн ордон дахь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй, хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

Зорилт 2-ын хүрээнд:

- Ажлын алба нь Ассамблейтай холбоотой мэдээ мэдээллийн найдвартай эх сурвалж байх;
- Үнэн зөв, судалгаан дээр үндэслэсэн мэдээ мэдээлэл, санал зөвлөмжийг цаг хугацаанд нь гаргаж өгөх;
- Шинээр гарч буй техник технологитой танилцан, ажил, үйлчилгээндээ нэвтрүүлж ажиллах;
- Өндөр хурд бүхий найдвартай интернэт сүлжээ, программ хангамжийн үйлчилгээ, хөдөлгөөнт тоног төхөөрөмж болон өндөр хурд бүхий хөдөлгөөнт интернэт сүлжээний технологийг үйлчилгээндээ ашиглах;
- Гишүүдэд үзүүлж буй үйлчилгээгээ гар ажиллагаатай, цаасан хэвлэл ашигладаг механик арга барилаас хэрэглэхэд хялбар, түргэн шуурхай цахим систем рүү шилжүүлэх.

Зорилт 3-ын хүрээнд:

- Ассамблейн гишүүд нэмэгдсэний хэрээр ажлын албаны ачаалал, үйлчилгээний чанар, төрөл тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- Ажлын алба нь ажил үүргээ чанартай хийж гүйцэтгэх үүднээс ажлын ачаалал болон нөөц бололцоогоо хянаж, уялдуулж байх;

- Ажлын алба нь үр ашиггүй зардлыг багасгаж, байгаа нөөц бололцоогоо үр ашигтай зарцуулах санхүүгийн оновчтой шийдвэр гаргаж байх;
- Ажилтнуудад шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал бодлоо илэрхийлэх, хувь нэмрээ оруулах боломжоор нь хангаж ажиллах;
- Ажилтнуудыг байгууллагын дотоод бүтэц, хэлтэс, албад нэг бүрийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар бүрэн ойлголт өгч, хоорондоо мэдээ мэдээллээ солилцон, харилцан уялдаа холбоотой ажиллах боломжоор хангах;
- Ажилтнуудад мэдээ мэдээлэл хайх, хадгалах систем нь хэрэглэхэд хялбар, боловсруулсан мэдээллээ байрлуулах, эргээд ашиглах боломжтой, үр дүнтэй байхад анхаарч ажиллах;
- Ажлын алба нь байнга өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн аудит, тайлан тооцооны стандарт, цалин хөлс, татвар, мэдээллийн эрх чөлөө, нээлттэй байх зарчим зэрэг үзүүлж буй үйлчилгээндээ гарч буй өөрчлөлт, шинэчлэлтийг мэдэрч, түүнтэй уялдаж ажиллах;
- Ажлын алба нь хууль дүрмээ баримталж, ажилтнуудаа мэргэшүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх болон эрсдэлийг тодорхойлох, даван гарах байгууллагын чадавхыг бий болгож ажиллах.

2.2.ИБУИНВУ

Нийтийн танхимын ажлын албаны 2016-2021 оны стратеги төлөвлөгөө¹⁶³:

1. Нийтийн танхимын үйл ажиллагаа, хяналт, хэлэлцүүлэг үр дүнтэй явагдахад дэмжлэг үзүүлэх:
Парламентын гишүүдэд тэдний хэрэгцээ шаардлага дээр үндэслэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, судалгаа мэдээллээр ханган, техник тоног төхөөрөмж болон бусад төрлийн үйлчилгээгээр хангаж үйлчилнэ.
2. Ард иргэдийг хууль тогтоох үйл ажиллагаанд оролцуулах, тэдний идэвхийг нэмэгдүүлэх:
Нийтийн танхимын үйл ажиллагааг ард иргэдэд нээлттэй болгож, ардчилал, ирээдүйн сайн сайхны төлөө ард иргэдийн идэвхтэй оролцоо хууль тогтоох үйл ажиллагаанд хичнээн чухлыг ойлгуулах. Залуучууд болон өсвөр үеийнхэн, нийгмийн халамж, анхаарал илүү шаардлагатай иргэдийг онцлон үзэж, Нийтийн танхимын үйл ажиллагаатай танилцуулах боломжийг бүрдүүлж ажиллана. ИБУИНХУ-д болон олон улсад парламентын нэр хүндийг өргөж ажиллана.
3. Парламентын аюулгүй байдал, тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллах:

¹⁶³<https://www.parliament.uk/documents/Strategy-for-the-House-of-Commons-Service-2016-2021-long-version.pdf>

Нийтийн танхимын өмнө тулгараад буй саад бэрхшээлийг даван туулж, хуримтлуулсан туршлага дээр үндэслэн шинэчлэл хийх. Лордын танхимтай хамтран ард иргэдэд нээлттэй байх үндсэн зарчмаа алдагдуулалгүй, парламентад нүүрлэж болзошгүй аливаа эрсдэлээс сэргийлэн ажиллана. Байнгын өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажиллана.

Зорилт 1-ийн хүрээнд:

- Тусгайлан байгуулагдсан түр хороодын үйл ажиллагааг үр дүнтэй байлгахад анхаарч, шаардлагатай мэдээ мэдээллээр ханган, зөвлөгөө өгч ажиллах;
- Цаг үеийн асуудлаар, Нийтийн танхимын нэгдсэн болон байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар мэдээ мэдээлэл бэлтгэн гишүүдэд танилцуулах;
- Нийтийн танхимын гишүүд болон тэдгээрийн туслах ажилтнуудыг өндөр чанар, хурд бүхий найдвартай техник технологиор хангаж, түүнийг ашиглах сургалт зохион байгуулж байх;
- Нийтийн танхимын гишүүдийн туслах, ажлын албаны ажилтнууд болон орон нутгийн тойрогт гишүүдээ төлөөлөн ажиллаж буй ажилтнуудыг дэмжин, хамтарч ажиллах.

Зорилт 2-ын хүрээнд:

- Нийтийн танхимын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан, тэдний сонирхож буй асуудлаар мэдээлэл өгч, ард иргэдийн санал бодлыг сонсож, хууль тогтоох үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах;
- Ард иргэдэд мэдээ, мэдээллийг дүрс бичлэгээр, хэвлэмэл байдлаар, инфографикаар гэх мэтчилэн олон төрлөөр түгээх;
- Нийтийн танхимын цахим хуудас, цаашлаад нийгмийн сүлжээ, хамтран ажилладаг болон харьяа байгууллагуудын цахим хуудсаар үйл ажиллагаагаа мэдээлэн ажиллах;
- Залуучууд, өсвөр үеийнхэн, бага орлоготой иргэд нь парламентын үйл ажиллагаа, ач холбогдлын талаар мэдээлэл хомс байдагтай холбоотой тэдэнд мэдээллийг ойлгомжтой, хялбар байдлаар хүргэхийг зорино. Парламентын боловсролыг түгээх аргыг өргөжүүлж, сургуулийн насны хүүхдүүдийг парламенттай, түүний үйл ажиллагаатай нь сургалтын хөтөлбөрөөр дамжуулан танилцуулах;
- Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шинэ арга замыг эрэлхийлж ажиллах;
- Олон улсын хэмжээнд парламентат ардчилсан ёсыг дэмжин, нөөц бололцоондоо тулгуурлан бусад орнуудын хөгжиж буй парламентын үйл ажиллагаанд шууд болон холбогдох бусад байгууллагаар дамжуулан дэмжлэг үзүүлж ажиллах.

Зорилт 3-ын хүрээнд:

- Лордын танхимтай хамтран 2020 он гэхэд Вэстминстерийн ордныг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэх;
- Парламентын ард иргэдэд нээлттэй болон аюулгүй байх боломжийг ханган, кибер болон биет халдлагаас сэргийлэх шинэ хамгаалалтыг нэвтрүүлэх;
- Уламжлалаа хадгалж, үйл ажиллагаагаа тогтмол сайжруулан, урт хугацааны зорилтоо хэрэгжүүлж тогтвортой ажиллахыг эрмэлзэнэ;
- Санхүүгийн үйл явц өмнөө тавьсан зорилттой дүйж буй эсэхийг нягталж, үр дүнтэй шийдвэр гаргах үүднээс санхүүгийн зөвлөгөө, мэдээллээр ханган, урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж ажиллах.

2.3.МОЛДОВА

Парламентын ажлын албаны 2011-2013 онд хэрэгжүүлэх Хөгжлийн тэргүүлэх 5 зорилт нь¹⁶⁴:

1. Хүний нөөцийн чадавхыг сайжруулах;
2. Орчин үеийн, ил тод, нээлттэй мэдээллийн бодлого боловсруулах;
3. Парламентын дэд бүтцийг бий болгох, сайжруулах;
4. Парламентын судалгаа, шинжилгээний чадавхыг бэхжүүлэх;
5. Хууль тогтоох үйл явцыг чанаржуулах юм.

Зорилт 1-ийн хүрээнд:

Парламентын ажлын албаны зорилтыг хэрэгжүүлэхэд чадварлаг хүний нөөцтэй байх нь чухал юм.

1. Парламентын хэлтэс, албадын чиг үүргийг тодорхойлсон парламентын ажлын албаны дүрмийг боловсруулах, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах;
2. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалтууд зохион байгуулах;
3. Ил тод, нээлттэй өрсөлдөөнт шалгалтаар ажилтнуудыг шалгаруулж авах;
4. Ажилтнуудыг мэргэшүүлэх стратегийн төслийг боловсруулах;
5. Парламентын гишүүд болон ажлын албаны ажилтнуудад зориулсан гарын авлагыг хэвлүүлж, тогтмол шинэчилж байх;
6. Ажилтнуудын ажлын үр дүнг ил тод, бодитойгоор үнэлж, шатлан дэвших зарчмыг боловсруулан мөрдөж ажиллах;
7. Парламент дээр дадлага хийх дадлагын журмыг боловсруулж ажиллах.

¹⁶⁴<https://agora-parl.org/sites/default/files/Strategic%20Development%20Plan%20for%20the%20Secretariat%20of%20the%20Parliament%20of%20Moldova%20%282011-2013%29.pdf>

Зорилт 2-ын хүрээнд:

Парламент, түүний ажлын албаны үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх шаардлагатай.

1. Парламентын харилцаа, холбооны зорилтыг тодорхойлох;
2. Иргэдэд зориулсан Мэдээ мэдээлэл, албан бичгийн төвийг нээн ажиллуулах;
3. Парламентын үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ, баримтыг парламентын үндсэн веб хуудсанд байршуулж байх;
4. Парламентын үйл ажиллагааг сурталчилсан, таниулсан нээлттэй өдөрлөг зохион байгуулах, иргэд олон нийтийг парламентын удирдлагуудтай уулзах боломжоор хангах;
5. Мэдээ мэдээлэл, албан бичгийг цахимаар шилжүүлэх цахим парламент мэдээллийн системийг бий болгож ажиллуулах;
6. Ил тод, нээлттэй, санхүүгийн болон хангамж үйлчилгээний бодлогыг боловсруулж ажиллах.

Зорилт 3-ын хүрээнд:

Хуулийн төсөл, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг засгийн газар болон парламентын хооронд, түүнчлэн парламент дотроо түргэн шуурхай, цахим хэлбэрээр хайж олох, илгээх, хүлээн авах боломжоор хангах.

1. Техник, тоног төхөөрөмжид үнэлгээ хийх;
2. Парламентын ажлын албаны харьяа (үйлчилгээ хариуцсан) байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх;
3. Парламентын хуралдаан дээр гишүүдийг цахимаар бүртгэх болон цахим санал хураалтын системийг нэвтрүүлэх;
4. Парламентын хуралдааны шууд орчуулгын болон дуу хураагуурын орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж ашиглах;
5. Архивын материалыг тоон системд хөрвүүлэх.

Зорилт 4-ийн хүрээнд:

Парламентын хууль тогтоох үйл ажиллагааг шаардлагатай судалгаа, мэдээ мэдээллээр хангах болон парламентаас баталсан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа шинжилгээ, хяналт шалгалтыг бодитой, үр нөлөөтэй явуулахад шаардлагатай мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх.

1. Ажлын албаны ажилтнуудад шаардлагатай мэдээ мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах боломжоор хангах;
2. Номын санг цахим системд шилжүүлэх;
3. Парламентаас гадна эрдэмтэн, судлаачидтай хамтарч ажиллах;
4. Парламентын хяналт шалгалтын чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудыг мэргэшүүлэх, хяналт шалгалтын үйл явцыг тодорхой болгох.

Зорилт 5-ын хүрээнд:

Хуулийн төсөл боловсруулах арга барил, үйл явцыг сайжруулах

1. Батлагдсан хууль болон хуулийн төслүүд нь Европын Холбооны хууль дүрэмтэй нийцэж буй эсэхийг нягтлах нэгж байгуулж ажиллах;
2. Хууль батлагдахаас өмнө болон батлагдсаны дараа нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг судлах, үнэлгээ хийх;
3. Хууль зүйн техникийн гарын авлагыг боловсруулах;
4. Хуулийн төслийн шаардлага хангасан, эсхүл хангаагүйг тодорхойлох үе шатыг парламентад хуулийн төсөл өргөн барих үйл явц дээр нэмж оруулах.

2.4.ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Төлөөлөгчдийн танхимын ажлын албаны 2016-2020 оны стратеги төлөвлөгөө¹⁶⁵:

Стратеги зорилт 1: Төлөөлөгчдийн танхим болон гишүүдэд чанартай үйлчилгээ үзүүлэх

1. Гишүүд болон парламентын бусад агентлагууд байгаа газраасаа мэдээллийг түргэн шуурхай авах, харилцан солилцох зэргээр ажил үүргээ үр дүнтэй, саадгүй хэрэгжүүлэх.

Үүнд мэдээллийн систем, технологи нь чухал үүрэгтэй бөгөөд парламентын үндсэн интернэт сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, парламентын гадна байрлах харьяа байгууллагуудыг нэгтгэн, сүлжээний хамрах хүрээг өргөжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх.

2. Гишүүд болон парламентын бусад агентлагуудыг чанартай үйлчилгээгээр хангах.

- *Хүний нөөц болон соёлын үйлчилгээ:*

Хүний нөөц болон соёлын баг хамт олон нь парламентын гишүүдэд шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Парламентын ажлын албаны хийгээд орон нутгийн иргэдийн хуралд ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг сургаж дадлагажуулах, тэдний чадавхыг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

- *Санхүүгийн үйлчилгээ:*

Санхүүгийн баг хамт олон нь парламентын гишүүдийн болон Парламентын ажлын албаны, түүнчлэн парламентын зөвлөх албаны төсөв, түүний зарцуулалтыг цаг хугацаанд нь тайлагнах, тэдгээрийн төсвөө зөв хянаж, зарцуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Төсөв, санхүүгийн тайлангаа интернэт сүлжээгээр хүлээн авах, хянах боломжийг олгохоор ажиллаж байна.

- *Улс орны нөхцөл байдалтай танилцуулах аяллын үйлчилгээ:*

Парламентын гишүүд, Парламентын ажлын албаны ажилтнууд, холбогдох яамдын ажилтнуудыг улс орны нөхцөл байдал, хүмүүсийн аж амьдралтай танилцуулах дотоодын аяллыг тус баг хамт олон зохион байгуулан ажиллаж байна.

¹⁶⁵<https://www.parliament.nz/media/2753/parliamentary-service-strategic-intentions-2016-2020.pdf>

- *Судалгаа, мэдээллийн үйлчилгээ:*

Номын сангаас үзүүлдэг тус үйлчилгээ нь парламентын гишүүдийн хувьд албан үүргээ гүйцэтгэхэд нэн чухал, шаардлагатай мэдээллийн эх үүсвэр болдог. Парламентын гишүүд болон парламентын ажлын албаны ажилтнуудад цаг үеийн нэн шаардлагатай мэдээ мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр түргэн шуурхай гарган өгч байна.

Стратеги зорилт 2: Хүртээмжтэй парламент

3. Ард иргэд парламентын үйл явцтай танилцаж, үйл ажиллагаанд нь оролцох.

- *Парламентын боловсрол:*

Оюутан сурагчдын сургалтын хөтөлбөрт Шинэ Зеланд улсын ардчилал, парламентын үйл ажиллагааны талаар мэдээллийг оруулж, оюутан сурагчид болон ард иргэдийг парламентын түүх, үйл явцтай танилцуулдаг. Өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд тухайн иргэн парламентын цахим хуудаснаас мэдээлэл авах боломжтой болсон.

- *Иргэдийг хүлээн авч уулзах үйлчилгээ:*

Иргэд болон парламентын гишүүдийн урьсан зочид долоо хоногийн 7 өдөр тойргийн гишүүдтэйгээ уулзан, Парламентын танхимаар зочлон, санал бодлоо илэрхийлэх боломжтой.

4. Парламент нь иргэд олон нийтэд нээлттэй үйлчлэх боломжийг нэмэгдүүлэх.

Иргэдийн парламенттай харилцах харилцааг нэмэгдүүлэх зорилгоор парламентын ордноор зочилж, парламентын болон хороодын хуралдааны үйл явцтай танилцах боломжоор ханган ажиллаж байна. Мөн парламентын ТВ-ийг ажиллуулж, үйл явцыг нэвтрүүлж байна.

Парламентын ордон нь түүхийн дурсгалт газрын нэг болохын хувьд улс орны нэн чухал ажил үйлчилгээг хэвийн явуулах үүднээс парламентын ордны барилга байгууламжийн аюулгүй байдлыг ханган, засвар үйлчилгээг тогтмол хийн ажиллаж байна. Парламентын ордон төдийгүй орон нутаг дахь харьяа байгууллагуудын аюулгүй ажиллагааны стандартыг ханган, гишүүд болон тойргийн сонгогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжоор хангадаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Kiribati Parliament Corporate Strategic Plan (2017-2022) https://agora-parl.org/sites/default/files/kiribati_parliament_corporate_strategic_plan_final_may_2010.pdf
- СТРАТЕГИЯ развития Жогорку Кенеша Кыргызской Республики до 2021 года <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/82056>
- National Parliament of Solomon Islands Strategic Plan 2017-2021 <http://www.parliament.gov.sb/files/Parliament%20Strategy/npsi17To21.pdf>
- Strategic Plan of the Parliament of Sierra Leone 2016-2019. With the support of United Nations Development Programme (UNDP) https://agora-parl.org/sites/default/files/parliament_strategic_plan_final-sierra_leone.pdf
- Парламент болон Тамгын газрын Стратеги төлөвлөгөө, <http://www.parliament.gov.zm/sites/default/files/documents/pages/Final%20National%20Assembly%20of%20Zambia%20Strategic%20Plan%281%29.pdf>
- STRATEGIC PLAN FOR THE 5th DEMOCRATIC PARLIAMENT 2014-2019 <https://www.parliament.gov.za/storage/app/media/StratPlan/5/strat%20plan%2013may2015.pdf>
- Strategic Plan 2014-2018 of the National Assembly of Pakistan http://www.na.gov.pk/uploads/1439219002_845.pdf
- Uganda - Five-year strategic plan for the Parliament (2014-2018) https://agora-parl.org/sites/default/files/uganda_-_five-year_strategic_plan_for_the_parliament_2014-2018.pdf
- Strategic development Plan 2014-2018. With the support of United Nations Development Programme (UNDP) <http://www.nab.gov.bt/assets/uploads/docs/download/2015/strategicplan.pdf>
- STRATEGIC PLAN OF THE PARLIAMENT OF THE REPUBLIC OF TRINIDAD AND TOBAGO, 2013-2018 <http://www.ttparliament.org/documents/2218.pdf>
- Wolesi Jirga Stretegic Plan 2011-2016 (Төсөн) https://agora-parl.org/sites/default/files/afghanistan_-_wolesi_jirga_strategic_plan_2011-2016.pdf
- Rwanda - Strategic Plan of the Parliament (2011-2015) <https://agora-parl.org/resources/library/rwanda-strategic-plan-parliament-2011-2015>
- https://www.parliament.act.gov.au/__data/assets/pdf_file/0006/1195737/Strategic-Plan-Office-of-the-Legislative-Assembly-2018-202.pdf
- <https://www.parliament.uk/documents/Strategy-for-the-House-of-Commons-Service-2016-2021-long-version.pdf>
- <https://agora-parl.org/sites/default/files/Strategic%20Development%20Plan%20for%20the%20Secretariat%20of%20the%20Parliament%20of%20Moldova%20%282011-2013%29.pdf>
- <https://www.parliament.nz/media/2753/parliamentary-service-strategic-intentions-2016-2020.pdf>